


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 8/161

Улаанбаатар хот

Г Г

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн 3.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг нэгдүгээр, нянгийн халдвартгүйтгэлийн зааврыг хоёрдугаар, халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах үед гарсан ослыг шалгаж шийдвэрлэсэн тухай актыг гуравдугаар, халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах үед гарсан ослын бүртгэлийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нар тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл технологийн газрын дарга /Л.Мөнхтулга/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/ нар тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны 114 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



A. ЦОГЦЭЦЭГ

080556



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 11-ны өдрийн
161 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮЕД АЖИЛЛАХ ХАЛДВАР ХАМГААЛАЛ, БИОАОУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДЭГЛЭМИЙН ЗААВАР

Зоонозын халдварт өвчний эмчилгээ, оношилгоо, лабораторийн үйл ажиллагаа, байгалийн болон хүний өвчний голомтод ажиллах явцад биохамгаалал, биоаюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.

Энэ зааврыг зоонозын халдварт өвчний эмчилгээ, оношилгоо хийдэг болон халдвартай ба сэжигтэй материалтай ажилладаг эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ажиллагсад өдөр тутам мөрдөнө.

1. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

1.1. Биологийн агент (БА)

Хүн, амьтан эсвэл ургамалд халдвар өдөөх, харшил эсвэл хордлого үүсгэх чадвартай бичил биетэн, түүний дотор хувиргасан амьд организм, эсийн өсгөвөр болон дотор шимэгч хамаарна.

1.2. Биоаюулгүйн кабинет (БАК)

Ажилтан халдварлах, ажлын байрны агаар болон хүрээлэн буй орчинд халдвар тархах эрсдэлээс сэргийлэх зорилгоор бичил биетний физикийн тусгаарлалтад ашиглаж буй төхөөрөмж юм.

1.3. Биологийн эрсдэл (БЭ)

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эх уурхай, гадаад орчны материал, дамжуулагчидтай хавьтах болон биологийн агентад өртөх магадлалыг илэрхийлнэ.

1.4. Биоаюулгүй байдал (БАБ)

Эмнэл зүйн болон оношилгоо, судалгааны лабораторит гүйцэтгэж байгаа ажлын сөрөг нөлөөнөөс ажилтнуудыг хамгаалах, биологийн аюулгүй байдлыг хангах арга, зарчмыг практикт хэрэглэх үйл ажиллагааг хэлнэ.

1.5. Био хамгаалал (БХ)

Бичил биетэн эсвэл тэдгээрийн хор алдагдах, хулгайлгадах эсвэл биологийн зэвсэг болгож гэмт үйлдэлд (тухайлбал: биотерроризмд) ашиглах эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ юм.

1.6. Халдвартай материал (ХМ)

Эмгэг төрүүлэгч бичил биетний амьд өсгөврийг агуулж буй материалууд хамаарна.

1.7. Сэжигтэй материал (СМ)

Хүн, амьтанд өвчин эсвэл эмгэг байдал үүсгэх боломжтой нян, вирус, риккетси, шимэгчид, мөөгөнцрөөс гадна рекомбинант, гибрид, мутант зэрэг янз бүрийн бичил биетнийг агуулсан, бүрэн батлагдаагүй боловч халдварын аюултай

байж болзошгүй материалыг хэлнэ.
— багасгартай бус

18 Халдвартай бүс

байж болзошгүй материалыг хэлнэ.
1.8. Халдвартай бүс
Эмгэг төрүүлэгч БА-ууд болон тэдгээрийг хадгалах үйл ажиллагаа хийгдэг тэдгээртэй ажилладаг лабораторийн нэг эсвэл хэд хэдэн өрөө, байр хамаарна.

1.9. Халдвартгүйтгэл

тэдгээртэй ажилладаг лабораторийн
1.9. Халдвартгүйтгэл
Гадаргуу дээрх өвчин үүсгэгч бичил биетийг өвчин үүсгэхгүй хэмжээнд
хүртэл цөөрүүлэх, устгах арга ажиллагаа юм.

1.10. Ариутгал

Хүртэл цөөрүүлэх, устгах арга ажиллагааг хэлнэ.
1.10. Ариутгал
Хими, физикийн аргаар багаж, материал дээр байгаа бүх төрлийн бичил
биетүүдийг бүрэн устгах арга ажиллагааг хэлнэ.

1.11. Гадаргуугийн цэвэрлэгээ

бийетүүдийг бүрэн устгах арга ажлыг
1.11. Гадаргуугийн цэвэрлэгээ
Механик үйлдэл бөгөөд бохирлогдсон зүйлийг усаар болон бусад угаалгын
бодис, химийн бодис хэрэглэн угаах, зарим тохиолдолд вакум угаагч, өндөр
даралттай усаар шүршиж тоос шороо, органик бодис болон толбыг арилгах үйл
ажиллагаа.

1.12. Ариутгалын бодис

1.12. Ариутгалын бодис
Арьс салстыг цочроохгүйгээр эмнэлгийн багаж хэрэгсэл, гадаргуу дээрх бүрээстэй, бүрээсгүй бичил биетнийг устгах зорилгоор ашигладаг химийн нэгдэл юм.

1.13. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент

1.13. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдаж, Хог хаягдал үүссэн цэгээс түүнийг ангилах, ялгах, савлах, цуглуулах, хадгалах, түр байршуулах, тээвэрлэх, халдвартгүйтгэх, устгах, дахин боловсруулах үйл ажиллагаа юм.

1.14. Нийт хог хаягдал

Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, энэ чиглэлээр судалгаа, сургалт, үйлдвэрлэл, хяналтын ажил эрхэлдэг байгууллагуудад үүсэх хий, шингэн, хатуу хог хаягдлыг хэлнэ.

1.15 Ердийн хог хаягдал

1.15. Ердийн хог хаягдал
Эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, агуулах, хонгил, орчны эдэлбэр газарт үүсэх ахуйн хог хаягдлыг хэлнэ.

1.16 Тусгай хог хаягдал

1.16. Тусгай хог хаягдал
Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус, бусад шингэн, ялгадас, эм, эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү, тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химийн болон цацраг идэвхит бодис зэрэг хог хаягдлыг хэлнэ.

1.17 Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX)

1.17. Хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)
Химийн эсвэл биологийн гаралтай бодисууд хүнд халдварлах, нөлөөлөхөөс хамгаалах зорилгоор ашиглаж буй тусгай өмсгөл (халад, бээлий, хамгаалах нүдний шил, амны хаалт, малгай, усны гутал)–ийг багтаасан материаллаг хэрэгсэл орно.

1.18. Дэглэм

1.18. Дэглэм
Зоонозын халдварт өвчнүүдийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, тандалт судалгаа, хяналтыг гүйцэтгэдэг эрүүл мэндийн ажилтнууд нь БА, халдвартай болон сэжигтэй материалтай ажиллахдаа мөрддөг аюулгүй ажиллагааны горим

юм.

1.19. Дэглэмийн байгууллага

Нян, вирус, эгэл биетний гаралтай байгалийн голомтот, зоонозын халдварт өвчнүүдийн шинжилгээ, судалгаа, хяналт сэргийлэлтийн үйл ажиллагааг эрхэлдэг, "Зоонозын халдварт өвчний үед ажиллах халвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар"-ыг мөрдөж хэрэгжүүлдэг байгууллагууд хамаарна.

1.20. Дэглэмийн зөрчил

Зоонозын халдварт хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг баримталж, ажиллаагүйн улмаас халварын аюулын эрсдэл багатай боловч энэхүү зааврын заалтыг зөрчсөн тохиолдлыг хэлнэ.

1.21. Дэглэмийн осол

БА, халдвартай болон сэжигтэй материалтай ажиллах явцад ажиллагсадын дунд болон нийгэмд халвар тархаж болзошгүй аюул, эрсдэл өндөртэй нөхцөл байдал үүсэхийг хэлнэ.

1.22. Халварын сэргийлэлт, хяналтын баг /ХСХ-ын баг/

Зоонозын халварын хяналт, сэргийлэлтийн үйл ажиллагаанд биоаюулгүйн удирдлагыг хэрэгжүүлэх эрх, үүргийг хүлээлгэж буй томилсон бүрэлдэхүүнийг хэлнэ.

1.23. Бичил биетний ангилаал

Зоонозын халдварт өвчин үүсгэгч бичил биетэнүүд олон улсын ангилаалаар биологийн аюулын II-IY түвшинд хамрагдана.

Хүснэгт 1. Монгол оронд зонхилон тохиолддог зоонозын халдварт өвчний үүсгэгч, зөөвөрлөгдөх боломжтой бичил биетний биологийн аюулын түвшний ангилаал

Бичил биетний нэр	Үг бичил биетнээр үүсгэгддэг өвчний нэр	ДЭМБ-ын ангилаал
Нэг. Нянгийн шалтгаант халдварууд:		
<i>Yersinia pestis</i>	Тарваган тахал	3
<i>Bacillus anthracis</i>	Бoom	3
<i>Franciscella tularensis</i>	Хулгана тахал	2
<i>Burkholderia mallei</i>	Ям	2
<i>Burkholderia pseudomallei</i>	Хуурамч ям	2
<i>Vibrio cholerae</i>	Холер	3
<i>Brucella spp</i>	Бруцеллэз	2
<i>Erhysipeloethrix rhusiopathiae</i>	Гахайн ёлом	2
<i>Leptospira interrogans</i>	Цусархаг хамшинж	2
<i>Listeria monocytogenes</i>	Листериоз	2
<i>Pasteurella multocida</i>	Пастериоз	2
<i>Yersinia psebdotuberculosis</i>	Хуурамч сурьеэз	2
<i>Borrelia spp</i>	Хачигт боррелиоз	2
<i>Yersinia enterocolitica</i>	Гэдэсний халдвартүрэвсэл	2
<i>Coxiella burnetii</i>	Ку чичрэг	3
<i>Rickettsia spp</i>	Хачигт риккетси	2
<i>Anaplasma phagocytophilia</i>	Анаплазмоз	2

Ehrlichia chaffeensis	Эрлихиоз	2
Хоёр.	Вирусын шалтгаант халдварууд:	
Marburg virus	Марбургийн цусархаг чичрэг	4
Ebola virus	Эболын цусархаг чичрэг	4
Lassa virus	Лассын цусархаг чичрэг	4
Tick-Born encephalitis virus	Хачигт энцефалит	3
Dengue virus	Денгийнчичрэг	3
WestNile virus	Баруун Нилийнчичрэг	3
Japanese encephalitis virus	Японы энцефалит	3
Yellow fever virus	Шар чичрэг	3
Hantavirus	Бөөрний хамшинжит цусархаг чичрэг	3
A influenza virus (H5N1)	Шувууны томуу	3
Rhabdovirus	Галзуу	3
CoronavirusCoV	Амьсгалын цочмог халтай хам шинж	1
Creamen-Congo Haemorragic fever virus	Крым Конгийн цусархаг чичрэг	3
MERS-CoV	Ойрхи-Дорнодын Коронавиуст халдварт	3
Гурав. Эгэл биетнээр үүсгэгддэг халдварууд:		
Toxoplasma gondii	Токсоплазмоз	2
Plasmodium spp	Хумхаа	2
Babesia spp	Бабезиоз	2
Criptosporidium spp	Криптоспиридоз	2

2. ДЭГЛЭМИЙН БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА:

2.1. Шинжилгээ судалгаа, ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний хүрээнд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах асуудлыг байгууллагын захиргаа хариуцна. 2.2. Халдварт өртөж болохуйц эд, биологийн гаралтай шингэн, хатуу шинжлэгдэхүүн болон өсгөврийг цуглуулах, хадгалах, зөөвөрлөх, тээвэрлэх, тэдгээртэй ажиллах явцад халдвараас сэргийлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.3. Дэглэмийн байгууллага бүр халдварын сэргийлэлт, хяналтын багийг томилж ажиллуулах ба дотоод халдвар бүртгэгдсэн тохиолдолд өвчтөнийг хэвтүүлж эмчлэх тусгаарлах байртай байна.

2.4. Ажилтнуудаас тодорхойгүй шалтгаанаар ажилдаа ирээгүй тохиолдолд байгууллагын жижүүрт яаралтай мэдэгдэнэ. Уг мэдээллийн дагуу байгууллагын эмч шалтгааныг тогтоож, шаардлагатай бол тусгаарлах тасагт хэвтүүлэн оношийг тодруулна. Ажиллагсдаас өвчний улмаас эмнэлэгт үзүүлэх тохиолдолд өөрийн ажлын онцлогийг танилцуулна.

2.5. Инженер техникийн ажилтнууд халдвартай бүсэд ажил, үүрэг гүйцэтгэхдээ хувийн хамгаалах хэрэгсэл (XXX)-тэй, тухайн нэгжийн дарга (эрхлэгч)-ын томилсон мэргэжилтний хяналт дор ажиллана.

2.6. Ажил дууссаны дараа тасаг, лабораториудыг цоожилж лацдан, түлхүүрийг жижүүрт хүлээлгэн өгнө. Жижүүр нь түлхүүрийн тоо, лацны тэмдгийг шалгаж хүлээн авна.

2.7. Ажлын бус цаг, амралтын өдрүүдэд лабораторид шинжилгээ, оношилгоо хийх, бичгийн ажлаар албан өрөөнд суух тохиолдолд ХСХ-ын багийн зөвшөөрлөөр ажиллана.

2.8. Ажлын цаг дууссанаас хойш 2 цаг хүртэлх хугацаанд бичгийн ажлаар албан өрөөнд суух тохиолдолд ХСХ-ын багийн зөвшөөрөлгүй ажиллаж болох ба түүнээс дээш хугацаагаар ажиллах бол зөвшөөрөл авна.

2.9. Гадны байгууллагын хүмүүсийг тухайн байгуулагад нэвтрүүлэхдээ тусгай хамгаалалтын дүрмийн дагуу түр үнэмлэх олгож, лабораторид ажиллах тохиолдолд ХСХ-ын багийн зөвшөөрлөөр хяналттай ажиллуулна.

3. АЖИЛЛАГСДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

3.1. Шинээр ажилд орох гэж буй хүмүүс нь 3 хоногийн дотор дэглэмийн зааврыг судалж, шалгалт өгнө. Шаардлагатай мэргэжилтнүүдээс жилдээ 1-2 удаа дэглэмийн шалгалт авна.

3.2. Шинээр ажилд орж байгаа хүн бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ /биохими, вирус, цусны дэлгэрэнгүй/ хийлгэсэн байна.

3.3. Халдвартай болон сэжигтэй материалтай ажиллах зориулалтаас хамааран ХХХ-ийг хэрэглэж, ажлын эцэст биеийн халууныг үзэж тусгай бүртгэлд тэмдэглэнэ.

3.4. Халдвартай болон сэжигтэй материалтай ажилласан тохиолдол бүрт хамгаалах өмсгөлийг халдвартгүйтгэсний дараа нэгдсэн угаалгад өгнө.

3.5. Эмгэг төрүүлэгч бичил биетэнтэй ажиллах, хуруу шил, соруур, бүрхүүл шил, хурц үзүүртэй багаж хэрэгсэлтэй болгоомжтой ажиллах, болзошгүй аюулын үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангана.

4. АЖИЛЛАГСДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ:

4.1. Лабораторийн ажилтнуудын эрүүл мэндийн байдал, үзлэг бурийн дүнг тэмдэглэх тусгай бүртгэлтэй байна. Лабораторит шинээр ажилд орж байгаа хүний эмнэлгийн үзлэгийн хуудас, шинжилгээний хариуг тухайн ажилтны хувийн хэрэгт нь хавсаргана.

4.2. Мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт илрүүлэх, тандах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор халдварт өртөх өндөр эрсдэлтэй ажилтнуудыг тодорхой давтамжтайгаар эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулна.

4.3. Эрүүл мэндийн үзлэгээр нэн мэдрэмтгий буюу ажлын байранд тэнцэхгүй, зайлшгүй хүндэтгэх шалтгаантай ажилтныг ажлын байрнаас шилжүүлэх, ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

4.4. Ажилтнуудыг халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамруулан бүртгэлд тэмдэглэнэ.

5. ЛАБОРАТОРИЙН АЖИЛЛАГСДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ:

5.1. Лабораторийн аюулгүй байдал, болзошгүй аюул, ослоос сэргийлэх арга хэмжээний талаар лабораторийн бүх ажилтнуудад ажлын байрны тасралтгүй сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулна.

5.2. Сургалтын хөтөлбөр нь дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

- Лабораторийн биоаюулгүй ажиллагаатай холбогдолтой тушаал, заавар, журам бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд
- Зоонозын халдварт өвчний эмгэг төрүүлэгч бичил биетний онцлог, өвөрмөц чанар, эрсдлийн үнэлгээ
- XXX-ийг хэрэглэх, өмсөх, тайлах дадал эзэмшүүлэх
- Хүн, мал, амьтан болон гадаад орчноос сорьц цуглуулах, хадгалах, зөвөрлөх, тээвэрлэх
- Микробиологийн түгээмэл үйлдлийн стандарт, аюулгүй ажиллагааны аргачлал, ур чадвар, лабораторийн шинжилгээний бүх шатанд халдварт өртөж болзошгүй өндөр эрсдэлтэй ажилбарыг аюулгүй гүйцэтгэх арга технологи
- Лабораторийн анхдагч, хоёрдогч хамгаалалт, лабораторийн биоаюулгүй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй ажиллах зааварчилгаа
- Лабораторийн шалтгаант болзошгүй аюул, ослын үед авах арга хэмжээ
- Ариутгал, халдвартгүйтгэл, хог, хаягдлын менежмент
- Лабораторит хөтлөгдөх анхан шатны бүртгэл маягтууд
- Лабораторийн биоаюулгүй ажиллагааны чиглэлээр олон улсад шинээр гарсан дэвшилтэй, техник, технологи

6. ЛАБОРАТОРИЙН АНХДАГЧ ХАМГААЛАЛТ, БИО АЮУЛГҮЙН ШААРДЛАГА:

6.1. Лабораторийн анхдагч хамгаалалт, био аюулгүйн тоног төхөөрөмж Уусгах, холих, нунтаглах, сэгсрэх, савлах, хурилдуурт эргүүлэх зэрэг ажилбараас халдвартай материал агаар дуслаар тархаж болзошгүй эрсдэлд өртөх боломжийг багасгах, арилгахад чиглэгдсэн зарим тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийг анхдагч хамгаалалт гэж үзнэ.

6.1.1. Био аюулгүйн кабинет (БАК)

- Биологийн аюулгүйн кабинет нь анхдагч өсгөвөр, нөөц материал болон оношилгоо хийх шинжлэгдэхүүн зэрэг халдварт үүсгэгч агуулсан сорьц, материалыг гадны нөлөөнөөс хамгаалах, халдвартай сорьцоос ажилтан болон орчинг хамгаалах зориулалттай.
- Зоонозын халдварт өвчний шинжилгээ, оношилгоо, судалгаа хийдэг лаборатори нь I-II зэрэглэлийн БАК-тай байна.
- Халдвартай агаар дусал үүсч болох шингэн ба хагас шингэн материалыг сэгсрэх, өөр гадаргуу руу эсвэл өөр шингэн үрүү юулэх, дусаах, холих, эсийн өсгөврийг соруураар авах, олон сувагт дусаагуур ашиглан халдварт үүсгэгчийн шингэрүүлсэн уусмалыг бичил орчинд тарааж суулгах, халдвартай материалыг жигд уусгах, бэхжүүлэх, хурилдуурт эргүүлэх, эсвэл амьтантай ажиллах зэрэг ажиллагааны үед БАК-ийг ашиглана.
- БАК-ийг лабораторийн хаалга, цонхинос зайдай, өрөөн доторхи агаарын урсгал хөдөлгөөн харьцангуй багатай байрлалд, засвар үйлчилгээ хийхэд хялбар байлгах зорилгоор кабинетийн бүх талыг

бусад зүйлээс 30-35см зайтай байрлуулна.

- БАК-ийг суурилуулах үед, байрлалыг сольж, хөдөлгөсөн, засвар үйлчилгээ хийсэн, шүүлтүүр сольсны дараа хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг нь үндэсний болон олон улсын үйл ажиллагааны стандартын дагуу гэрчилгээжүүлж, баталгаажуулна. Цаашид үйлдвэрлэгчийн зааврын дагуу НЕРА шүүлтүүрийн алдагдал, доош чиглэсэн урсгалын хурд хүч, нүүр хэсгийн хурд, сөрөг даралт болон агааржуулалтын түвшин, агаарын угааржилтын байдал, дохио болон түгжээнүүд болон нэмэлтээр цахилгааны алдагдал, гэрлийн эрчим, хэт ягаан туяаны эрчим, шуугианы түвшин, чичиргээ зэргийг мэргэжлийн техникч тогтмол шалгана.
- БАК-ийг ажиллуулахын өмнө болон ажиллуулсны дараа дотор гадаргууг 70 хувийн спиртээр халдвартгүйтгэнэ.

6.1.2. Хувийн хамгаалах хэрэгсэл

Хүнийг бичил биетэний халдварталт, химиин эсвэл биологийн гаралтай бодисуудын нөлөөллөөс хамгаалах зориулалттай бөгөөд болзошгүй эрсдэлзэс хамгаалж чадахуйц шаардлагыг хангасан байна.

6.1.2.1. Хувийн хамгаалах хэрэгсэл нь даавуун материалыаар хийсэн буюу уламжлалт эсвэл нэг удаа хэрэглэхэд зориулан үйлдвэрлэсэн хамгаалах өмсгөл байна.

6.1.2.2. Ажиллагсад нь хамгаалах өмсгөл өмсөж, тайлах дарааллыг бүрэн эзэмшсэн байна.

6.1.2.3. Хамгаалах өмсгөлийг иж бүрдлээр нь I-IV зэрэгт ангилж (хүснэгт 2), лабораторийн ажилтнууд биеийн хэмжээндээ болон тухайн ажилбарт тохирох бүрдлийг сонгож хэрэглэнэ.

Хүснэгт 2. Хамгаалах өмсгөлийн иж бүрдэл

№	Бүрдэл	Өмсгөлийн зэрэг			
		I	II	III	IV
1	Эмнэлгийн урт ханцуйтай цамц, өмд	+	+	+	+
2	Богино оймс	+	+	+	+
3	Усны буюу ажлын гутал	+	+	-	-
4	Хошуу алчуур	+	+	-	-
5	Халад	+	+	+	-
6	Амны хөвөн марлин хаалт	+	+	-	-
7	Нүдний хамгаалах шил	+	-	-	-
8	Резинэн бээлий	+	+	+	-
9	Гарын алчуур	+	+	+	-
10	Резинэн /хулдаасан/ хормогч	+	-	-	-
11	Резинэн эсвэл хулдаасан ханцуйвч	+	-	-	-
12	Эмнэлгийн халад	-	-	-	+
13	Эмнэлгийн малгай	-	-	+	+
14	Түрийтэй шаахай*	-	-	+	+

Тайлбар:(+) тэмдгээр тэмдэглэсэн нь сонгох бүрдэл


* халдвартгүйтгэхэд хялбар, гөлгөр гадаргатай, битүү шаахай

6.1.2.4. Хамгаалах өмсгөлийн халадны урт нь хүний шилбэний гуравны хоёрыг далд оруулахуйц, хойд талдаа лав зөрж байхаар баруун талын оёдлын нүхээр сүвлэгдэн биеийн урд талд хөвөрхөн уях бүстэй, ханцууд гарын шууг бүтэн ороох бүчтэй байна.

6.1.2.5. Халадны захны урт 54-57 см, өндөр нь 6-7 см-ээс багагүй байна. Халадны захны бүчийг урагш нь сүвлэгдэхээр мөрний тушаа захны залгасан оёдлоос 1.5 см дээд хэсэгт нүх гаргана.


6.1.2.6. Амны хөвөн марлин хаалтны урт нь 125 см, өргөн нь 50 см байна. Хэмжиж авсан марлийн өргөн 2 талаас 50 см (голоор нь) урттай хайчлан маскны бүч гаргана. Голын хайчлаагүй үлдээсэн зайд хөвөнг 25x17см хэмжээтэй зайд 1-1,5 см-ийн зузаантай зулж тавиад хоёр урт талын илүүдэл марлиар бүтээж, хөвөнг бүрэн халхлан хучина. Оёдол оруулалгүйгээр хийнэ. 2 ширхэг хөвөн бөмбөлөг хийж бэлэн болсон амны хаалтанд тавьж нэг бүчээр нь ороож цэвэр цаасанд боож ариутгана. Ариутгасан огноог цаасан дээр нь бичнэ. (Зураг 1)

Зураг 1. Амны хөвөн марлин хаалт



6.1.2.7. Хошуу алчуурын ижил талууд 115-120 см, урт тал нь 160-165 см, өндөр нь 82-84 см хэмжээтэй байна. (Зураг 2)

Зураг 2. Хошуу алчуур



6.1.2.8. Халад, комбинзон зэргийг хүйтний улиралд дулаан хувцасны гадуур өмсөхөөр том хэмжээтэй хийнэ.

6.1.2.9. Усны гутал буюу ажлын гутал нь тухайн хэрэглэгчийн өмсдөг хэмжээнээс нэгээс хоёр хэмжээгээр том байна.

6.1.2.10. Нудний шил нь аль ч хэсгээр агаар нэвтрэхээргүй битүү хүрээтэй,

хамрын хэсгийн холбоос нь өргөн, өнгөгүй шил байна. Хагардаггүй материалыаар хийгдсэн, нүүрийг бүрэн бүрхдэг, малгай болон бэхэлгээгээр толгойд бэхлэгддэг нүүрний хамгаалалтыг хэрэглэж болно.

6.1.2.11. Хамгаалалтын болон аюулгүй шил, нүүрний хамгаалалтыг лабораториос гадуур хэрэглэхгүй.

6.1.2.12. Нэг удаагийн хэрэглээний резин, винил, нитрил материалыаар хийсэн бээлийг хэрэглэж, лабораторийн бохир хаягдалтай хамт устгана. Дахин хэрэглэх бээлийг мөн хэрэглэхдээ зөв угаах, тайлах, цэвэрлэх, халдвартгүйтгэхийг анхаарна.

6.1.2.13. Хамгаалах өмсгөлийн зэрэглэл, түүнийг хэрэглэх тохиолдлууд:

6.1.2.13.1. Нэгдүгээр зэргийн хамгаалах өмсгөл

- Зоонозын халдварт өвчний үүсгэгчийн цэвэр өсгөвөр, түүний сэжигтэй материалтай ажиллах, амь сорьцын амьтанд халдварт хийх, цус авах, халууныг үзэх, хооллох, гадны шимэгч тэжээх (хооллох), арчлах, хоривчийг солих, дээрх өвчний үүсгэгч дээр халдварт хийсэн амьтанд эмгэг судлалын шинжилгээ хийх;
- Зэрлэг амьтны тарга тэвээрэг, нас хүйсийг тодорхойлох, туршлагын амьтныг маллах, хооллох, гадны шимэгчдийг самнах, эмгэг судлалын шинжилгээ хийх, амьтны зэм, үхдэлийг тодорхойлох, булинга бэлтгэх, ноохойг авах, үзэх;
- Махчин шувуудын гулгидас, амьтдын ялгадас зэргийн бүтцийг тодорхойлох, анхны боловсруулалт хийх, шинжилгээнд соруулж авах;
- Зоонозын халдварт өвчнүүдийн өндөр хоруутай үүсгэгчээр туршилт хийх, тэдгээрээс эсрэгтөрөгч бэлдэх, өсгөврийг хуурайшуулах, ууршигч бодисонд нянгийн булинга бэлтгэх, юулэх (шингэн азот түүнтэй адил);
- Тарваган тахал, боом болон ям өвчний уушгины хэлбэрийн өвчтэй буюу сэжигтэй өвчтөн, тэдгээрийн I хавьтагсдыг тээвэрлэх, хүлээн авах, халдварт судалгаа хийх, өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэжигтэй дудллаганд явах, онош тодруулах, өвчний голомтод халдвартгүйтгэл, шавьжгүйтгэл хийх, нас барагчийн цогцост эмгэг судлалын шинжилгээ хийх, тээвэрлэх, оршуулах, түүнд оролцох;

6.1.2.13.2. Хоёрдугаар зэргийн хамгаалах өмсгөл

- Холер, боомын арьс, гэдэс, үжил, ямын арьсны хэлбэрийн сэжигтэй өвчтөний материалыг шинжлэх, өвчтөн тэдгээрийн I хавьтагсдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэх, өвчтөнд халдварт судалгаа хийх, голомтод нь байнгын болон эцсийн халдвартгүйтгэл хийх, нас барагчийн цогцосыг зөөвөрлөх, эмгэг судлалын шинжилгээ хийх, оршуулгын үйл ажиллагаа

6.1.2.13.3. Гуравдугаар зэргийн хамгаалах өмсгөл

- Зоонозын халдварт өвчин судлалын лабораториудад шинжилгээ, оношилгоо, судалгаа хийх, тэдгээр өвчний өсгөвөр, материалыг зөөвөрлөх, хүлээн авах, олгох

- БАК-д хийгдэх ажилбарууд (маск болон хамгаалалтын нүдний шилийг нэмэлтээр хэрэглэж болно)

- Мэрэгчдийн арьсаар сургалт, үзмэрт зориулсан чихмэл хийх, дээрх зориулалтаар амьтан өвчих, формалинд хийх (амны хаалт, нүдний шилийг нэмж хэрэглэнэ.)

- Гадны шимэгчийг тодорхойлох, бэлдмэл хийх, унтуулсан гадны шимэгчийг шинжлэх

6.1.2.13.4. Дөрөвдүгээр зэргийн хамгаалах өмсгөл

- Нян судлалын лабораториудад цэвэрлэгээ, үйлчилгээ хийх (резинэн бээлий, амны хаалт нэмж хэрэглэнэ)

- Тэжээлт орчин, урвалж захиалах, авах, урвалж, бодис болон оношлуур найруулах, шалгах, халдвартгүйтгэсэн материалд ийлдэс судлалын болон удам зүйн шинжилгээ хийх, бусад ердийн ажилбарууд хийх, аяга, хуруу шилэнд бичлэг хийх, бүртгэл тэмдэглэл хөтлөх;

- Амьтан болон шимэгч судлагч, лаборант, жолооч, анчид талбайд ажиллах (нэмэлтээр амны хаалт, бээлийтэй ажиллах)

- Хүний өвчний голомтод эмнэлгийн халдвартгүй бүсэд ажиллах

6.1.2.14. Уламжлалт хамгаалах өмсгөлийг өмсөх дараалал

Хүснэгт 3.

Дараалал	Хамгаалах өмсгөл	Тайлбар
1	Эмнэлгийн урт ханцуйтай цамц, өмд	
2	Богино оймс	
3	Усны гутал	
4	Шаардлагатай тохиолдолд чагнуур	
5	Хошуу алчуур	
6	Тахлын халад	Халадны захны бүч, бүсийг зүүн урд талдаа, хоёр ханцуйны бүчийг шууны гадна хэсэгт тус тус хөвөрхөн уяна.
7	Амны хаалт (хөвөн марлин, шүүлтүүртэй амны хаалт)	Амны хаалтны тохирсон эсэхийг шалгах - гараараа амны хаалтны өмнө талаас барьж огцом амьсгаа гаргахад хамгаалалт дотор нэмэх даралт үүсч гадагш хий гарахгүй байх - гүнзгий амьсгаа авахад сөрөг даралт үүсч хамгаалалт таны нүүрэнд наалдах
8	Нүдний хамгаалах шил	Нүдний шил хүрээндээ сайн бэхлэгдсэн эсэхийг шалгаж шилний дотор талд үл цантуулагч тусгай харандаа эсвэл хатсангарын савангаар зурж цанталтаас сэргийлнэ.
9	Резинен бээлий	Өмсөхийн өмнө бутэн эсэхийг шалгана.
10	Гарын алчуур	Гарын алчуурыг халадны бүсний баруун урд талд 2/3-ыг нь гадна талд унжиж байхаар хавчуулна.

Жич:

- Эмгэг судлалын шинжилгээний үед хулдаасан хормогч, ханцуйвчийг нэмж хэрэглэх ба резинэн бээлийг давхарлаж өмсөнө.
- Хамгаалах өмсгөлтэй 3-аас дээш цаг ажиллахгүй.

6.1.2.15. Хамгаалах өмсгөлийг тайлах дараалал

Хамгаалах өмсгөлийг тайлах үйлдэл бүрийн дараа бээлийтэй гарыг

халдвартгүйтгэх уусмалд 1-2 минут угаасны дараа зөвлөн хөдөлгөөнөөр доорх дарааллаар тайлна.

1. гарын алчуур
2. чагнуур
3. нүдний хамгаалах шил
4. амны хөвөн марлин хаалт
5. халад
6. хошуу алчуур
7. резинэн бээлий
8. усны гутал
9. Богино оймс

6.1.2.16. Хамгаалах өмсгөлийг тайлах үйлдэл

- Гарын алчуурын бохир хэсгийг дотогш хумих маягаар ороон сугалж авна.
- Хулдаасан хормогч ба ханцуйчийг хөвөнд шингээсэн халдвартгүйтгэх уусмалаар арчиж норгоод гадна талыг нь дотогш нь эвхэж тайлна.
- Давхар бээлийний гадна талыг нь тайлна.
- Гуталтай хөлөө халдвартгүйтгэх уусмалтай түмпэнд дүрж, уусмал дотор байгаа хөвөнгөөр түрийнээс нь доошуулж, тойруулах чиглэлээр арчиж гаргах ба нөгөө хөлөө дээрх маягаар арчиж халдвартгүйтгэнэ. Гутал тус бүрт өөр өөр норгосон хөвөн хэрэглэнэ.
- Арьсны ил хэсэгт хүргэхгүйгээр чагнууруыг авна.
- Нүдний хамгаалах шилний гаднах хүрээнээс хоёр гараараа барьж урагш, дээш, хойш гэсэн дарааллаар авна.
- Амны хаалтны гадна талыг нүүрэндээ хүргэхгүйгээр тайлна.
- Халадны зах, бүсний уяанаас нь татаж тайлна. Халадыг хоёр гараа зөрүүлж мөрний хэсгээс барьж урагш нь эгц татаж биеэс хөндийрүүлэн бохир хэсгийг дотогш хумих маягаар эвхэж авна.
- Хошуу алчуурын үзүүрүүдийг толгойн орой дээр авчирч, нөгөө гараараа 3 талыг дотроос нь гадагш эвхэж цуглувлан тайлна.
- Бээлийний шуумаг хэсгийг урагш эргүүлж арьсанд хүргэлгүйгээр тайлна. Резинэн бээлийг тайлж цоорсон эсэхийг гар угаах уусмал дотор хийж шахан шалгана.
- Хамгаалах хувцсыг тайлсны дараа гараа 70%-ийн этилийн спиртээр арчиж, савантай бүлээн усаар сайтар хөөсрүүлж угаана.

6.1.2.17. Нэг удаагийн хамгаалах өмсгөлийг өмсөх дараалал

Нэг удаагийн хамгаалах өмсгөл нь биеийг бүрэн халхалсан, шингэн нэвтрүүлдэггүй материалыар хийгдсэн тул 2 цаг тутамд солих шаардлагатай.

1. Эмнэлгийн урт ханцуйтай цамц, өмд
2. Комбинзон
3. Хамгаалалтын улавч, шаардлагатай тохиолдолд усны гутал
4. Шүүлтүүртэй амныхаалт (N95, N100)
5. Нүдний хамгаалах шил (хамгаалагч шил)
6. Давхар резинэн бээлий (Үүсгэгчийн зэргээс шалтгаалан давхар бээлий

өмсөнө)

6.1.2.18. Нэг удаагийн хамгаалах өмсгөлийг тайлах үйлдлийн дараалал

Хамгаалах өмсгөлийг тайлах үйлдэл бүрийн дараа бээлийтэй гарыг

халдвартгүйтгэх уусмалд 1-2 минут угаасны дараа зөвлөн хөдөлгөөнөөр доорх дарааллаар тайлна.

1. Гадна резинэн бээлий
2. Комбинзон
3. Хамгаалалтын улавч
4. Шүүлтүүртэй амны хаалт (тохируулан шалгана)
5. Нүдний хамгаалах шил
6. Дотор резинэн бээлий
7. Эмнэлгийн урт ханцуйтай цамц, өмд

Хэрэглэсэн бээлийг тайлах:

- Нэг талын бээлийтэй гарын хурууны үзүүрээр нөгөө гарын бээлийний гадна талаас татаж дотор талыг гадагш эргүүлэн тайлна.
- Тайлсан бээлийг бээлийтэй гаргат атгаж, бээлийгүй гарын хурууг нөгөө гаргат байгаа бээлийний дотор талаар оруулж урагш татан дотор талыг нь гадагш эргүүлэн тайлна.
- Бээлийг тайлахад нэг бээлий нь нөгөө бээлийний дотор орсон байна.

6.1.2.19. Эрүүл мэндийн ажилтнууд хамгаалах хувцас хэрэгсэлтэй эмнэлгийн бусад тасаг нэгжээр явах, хурал, зөвөлгөөн, эмнэлгийн хоолны газар, бие засах өрөөнд орох, эмнэлгийн орчноос бусад газар сэлгүүцэх, хамгаалах өмсгөлийг гэртээ аваачиж угаах зэргийг хориглоно.

6.1.2.20. Ажилтнуудын эмнэлгийн урт ханцуйтай цамц, өмд, халад, ажлын шаахайг хадгалах шүүгээ тусдаа байна

7. ЛАБОРАТОРИЙН ХОЁРДОГЧ ХАМГААЛАЛТ, БИО АЮУЛГҮЙН ШААРДЛАГА:

7.1. Лабораторийн барилга байгууламжийн зохион байгуулалт, бүтэц нь ажиллагсдыг хамгаалах, лабораториос санамсаргүйгээр тархаж болох халдвартай үүсгэгчээс хүн ам, хүрээлэн буй орчныг хамгаалах зориулалттай байна. Үүсгэгчийн био аюулын түвшингээс хамаарч барилга байгууламжийн бүтэц, тоноглол ялгаатай байна.

7.1.1. Лабораторийн өрөө нь хана, шал, цонх нь бүтэн, хаалга бүрэн хаагддаг, гар угаах, хатаах хэрэгсэл суурилуулсан, өрөөнд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хангалттай тусч байх шаардлагатай.

7.1.2. Лабораторийн шал нь цэвэрлэх болон халдвартгүйтгэхэд хялбар, хатуу болон тэгш гадаргуутай материалыар хийгдсэн, өрөөнүүдийн цонхыг төмөр тороор хамгаалж бэхэлсэн байна.

7.1.3. Лабораторийн нөхцөлд үүсч болох эрсдэл болон хими, гал, цахилгааны аюулаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

7.1.4. Суурин лаборатори нь онош зүйн, ариутгал-халдвартгүйтгэлийн гэсэн хоёр хэсэгтэй байна. Онош зүйн хэсэгт ажлын хувцас солих, онош зүйн лабораториуд, түүний өмнөх өрөө, амь сорьцын лаборатори, албан ажлын өрөө байна. Ариутгал халдвартгүйтгэлийн хэсэг нь ариутгал, халдвартгүйтгэл, шил сав угаалга, бэлтгэлийн зэрэг өрөөнүүдтэй байна.

7.1.5. Онош зүйн лаборатори, бокс нь шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

7.1.6. Лабораториудын өрөө, боксуудын байршил нь халдвартайгаас халдвартгүй хэсэг рүү чиглэсэн урсгалтай байна.

7.1.7. Амь сорьцын лаборатори нь хамгаалах өмсгөл өмсөх, тайлах өрөө, амьтан халдварлуулах, эмгэг судлалын шинжилгээ хийх, халдварлуулсан амьтныг хадгалах, амьтан, шимэгч судлалын хэсэгтэй байна.

7.1.8. Амь сорьцын лабораторийн өрөөнүүдийн цонх нь төмөр торон хамгаалалттай, шал, хана нь мэрэгч амьтан нэвтрэхээргүй, өрөөний хаалганы босго нь 5-10 см өндөртэй байна.

7.1.9. Хээрийн шинжилгээний үед вагон, авто лаборатори, гэр, майхан зэргийг дэглэмийн шаардлагад тохируулан тоноглож лабораторийн зориулалтаар түр ажиллуулж болно.

7.1.10. Хээрийн лабораторийг худаг, гол, булгийн усны ундаргаас 100 метрээс багагүй, ажиллагсдын байрнаас 50 метрээс доошгүй зайд, ажилчдын жорлон, бохирын усны цооногийг салхины ноёлох чиглэлийн доод талд байрлуулна.

7.1.11. Хээрийн шинжилгээний ангийн байршилыг халдвартай ба халдваргүй бүсэд хувааж, халдваргүй бүсэд ажилчдын байр, хооллох хэсэг, халдвартай бүсэд лаборатори, амь сорьцын ба халдваргүйтгэлийн хэсэг орно.

7.2. Халдвартай материал, хог хаягдлын халдваргүйтгэл

Лабораторийн шинжилгээний явцад халдвартай эсвэл халдвартай байж болзошгүй хаягдал (өвчтөний сорьцууд, амьтны задлан шинжилгээний явцад гарсан эд, эрхтэний хэсэг, хугацаа нь дууссан, бохирдсон, хориглосон, хагарч хэмхэрсэн эм био бэлдмэл, хий агуулсан бортон хэлбэртэй болон аэрозолтой, нэг удаа хэрэглэх зориулалт бүхий хийтэй савнууд, бичил биетний ургацтай тэжээлт орчин, уусмал, гадаад орчноос цуглувансан сорьц, материалыуд, гадны шимэгч, үе хөлтөн, хэрэглэсэн бээлий, суулгацтай тэжээлт орчин), зүү тариур болон бусад хурц ирмэгтэй багаж хэрэгсэл зэрэг хог хаягдал гарна.

7.2.1. Халдвартай материал, хог хаягдлыг савлах, түр хадгалах

7.2.1.1. Лабораториуд нь халдвартай материалыг хадгалах зориулалттай хөргөгч, өнгөөр ялгасан уут, саваар хангагдсан байна. Түр хадгалагдаж байгаа халдвартай материалыудыг хадгалагдаж буй хугацаа, дугаар, савлалтын байдал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан анхан шатны бүртгэлд тэмдэглэнэ.

7.2.1.2. Амархан цоорч гэмтэхээргүй, шингэн нэвчихгүй, хуванцар, металл, полиэтилен, полипролилен, зузаан цаасан материалыар хийгдсэн хар, шар, улаан өнгийн уутыг эсвэл эдгээр өнгөөр ялгаж будсан, таг бүхий хувин, бикс зэргийг халдвартай хаягдлыг хадгалахад ашиглана.

7.2.1.3. Халдваргүй (ахуйн) хаягдлыг энгийн хог хаягдалтай нийлүүлэн хар өнгийн уутанд эсвэл хогийн саванд, халдвартай материалыд хэрэглэсэн хурц ирмэгтэй хаягдлыг аюулгүй хайрцагт эсвэл тагтай, цоорхооргүй саванд тус тус хийнэ.

7.2.1.4. Автоклаваар халдваргүйтгэсний дараа угааж цэвэрлээд дахин ашиглах халдвартай материалыг шар өнгөтэй уут эсвэл тагтай саванд, автоклаваар халдваргүйтгэсний дараа хаяж устгах болон шууд шатаах халдвартай материалыудыг улаан өнгийн уут эсвэл тагтай саванд тус тус хийнэ.

7.2.1.5. Хог хаягдлын хэмжээ уут, савны 2/3 хэмжээнд хүртэл дүүрсэн тохиолдолд тэдгээрийг битүүмжлэн, хогийг зориулалтын тэргэнцэрээр түр хадгалах өрөө рүү зөөвөрлөнө.

7.2.1.6. Түр хадгалагдаж байгаа халдвартай материалыг хадгалагдаж буй хугацаа, дугаар, савлалтын байдал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан бүртгэлд тэмдэглэнэ.

7.2.1.7. Хог хаягдал хариуцсан ажилтан “Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, халдвартгүйтгэх, тээвэрлэх, устгах” зааврын дагуу ажлын өдөр бүр ажил эхлэхээс өмнө лабораториудаас хог хаягдлыг цуглуулан авч хог халдвартгүйтгэх өрөө рүү зөөвөрлөж, даралтат уураар халдвартгүйтгэсний дараа эмнэлгийн хог хаягдлыг устгах тусгай үйлчилгээнд хүлээлгэн өгч, устгуулна.

7.2.1.8. Шинжилгээний хариу гартал үлдээх шаардлагатай халдвартай материалын эх хувийг лабораторит зориулалтын хөргөгчид хадгална.

7.2.2. Халдвартай материал, хог хаягдлын химийн халдвартгүйтгэл

7.2.2.1. Халдвартгүйтгэлд хэрэглэх химийн бодисыг 16°C-ээс доошгүй хэмтэй усанд шаардлагатай өтгөрүүлэг, хэмжээгээр найруулан бэлтгэж, нян, вирус, риккетси, эгэл биетэн, мөөгөнцөрт үйлчлэх хугацааг нарийн баримтална.

7.2.2.2. Хүхэр болон азот хүчлийн аммони, наштирийн спирт зэргийг идэвхижуулэгч бодисоор ашиглаж болно.

7.2.2.3. Халдвартгүйтгэлийн уусмал найруулах үед нүдний хамгаалах шил, шүлтэнд тэсвэртэй резинэн бээлий, нягт даавуун ажлын хувцас, тусгай баг, амны хаалт зэргийг ажлын байранд бэлэн байлгана.

7.2.2.4. Халдвартгүйтгэлийн бодис арьсанд хүрч улайх, хорсох үед усаар угааж 5%-ийн цууны эсвэл лимоны хүчлээр шавших, нүдний салст улайж үрэвсвэл 1%-ийн борийн хүчлээр угааж зовхинд нь нүдний салстын үрэвслийн эсрэг зориулалтын тос хэрэглэх, амьсгалын зам хордсон, цочирсон үед цууны болон лимоны хүчил дусаасан халуун усны уураар утах гэх мэт арга хэмжээ авна.

7.2.2.5. Хлорын агууламжтай халдвартгүйтгэлийн бодисуудыг (жавелион, хлорын шохой, гипохлорид кальци гэх мэт) тохиromжтой саванд хийж, харанхуй, сэргүүн, чийгүй өрөөнд битүү таглаж хадгалах ба 3 сар тутамд идэвхитэй хлорын хэмжээг тодорхойлсон байна.

7.2.2.6. Этилийн спиртийг нян, липид агуулсан вирус, мөөгөнцрийн эсрэг 70%-иар тооцож бэлтгэн арьсан дээр хэрэглэх, лабораторийн болон БАК-ийн ажлын гадаргыг халдвартгүйтгэхэд ашиглах бөгөөд ууршихаас сэргийлж ажлын уусмалыг сайтар таглаж хадгална.

7.2.2.7. Өвчтөний, лабораторийн болон бусад өрөө, тасалгааны халдвартгүйтгэлийн үед бодисыг 1m² талбайд ноогдохоор тооцож найруулна.

7.2.2.8. Лабораторийн багаж, хэрэгсэлийн халдвартгүйтгэлийн үед зэврүүлдэггүй бодис сонгон хэрэглэнэ.

7.2.2.9. Халдвартгүйтгэлд ашиглаж буй бодисын хадгалалтын горим, өтгөрүүлэг, үйлчлэх хүрээ зэргийг сайтар шалгана.

7.3. Лабораторийн цэвэрлэгээ, халдвартгүйтгэл

7.3.1. Цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийг батлагдсан журмын дагуу хийх ба уг журамд их болон байнгын цэвэрлэгээ хийх давтамж, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, ялгааг тусгасан байна.

7.3.2. Байнгын цэвэрлэгээ, үйлчилгээг ажил эхлэхийн өмнө ариутгагч, бэлдмэлчин нар тухайн лаборатори, бокст хийж, шинжлэгдэж байгаа үүсгэгчээс хамааран халдвартгүйтгэлийн уусмалыг ариутгагч тухай бүр шинээр найруулж бэлтгэнэ.

7.3.3. Шинжилгээ, судалгааны ажил бүрэн дууссаны дараа лабораторид эцсийн халдвартгүйтгэл, их цэвэрлэгээг ариутгагч, бэлдмэлчин нар хийж тэмдэглэл

хөтөлнө.

7.3.4. Лабораторийн боксын ширээ, БАК-ыг ажил дууссаны дараа лаборант халдвартгүйтгэнэ.

7.3.5. Лабораторийн хана шал, бусад тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гадаргууг арчиж цэвэрлэхдээ тоос, бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ.

7.3.6. Хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлээс эхэлж дээрээс доош нь чиглэлтэй цэвэрлэгээг хийнэ.

7.3.7. Лабораторийн цэвэрлэгээ, үйлчилгээ дууссны дараа агаарыг нян устгах гэрлээр халдвартгүйтгэнэ.

7.3.8. Лабораторид шаардлагатай зөвлөн эдлэл (хуруу шилний бөглөө, хөвөн марлин маск гэх мэт), шил савны угаалгыг бэлдмэлчин хариуцан гүйцэтгэнэ.

7.3.9. Байнгын болон их цэвэрлэгээ, эцсийн халдвартгүйтгэл хийх үед хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.

7.3.10. Цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалыг өөр лаборатори өрөөнд ашиглах, хооронд нь сольж хэрэглэхийг хориглоно.

7.3.11. Зоонозын халдварт өвчний халдвартай ба сэжигтэй материалыг хими, физикийн аргаар халдвартгүйтгэнэ.

7.3.12. Халдвартгүйтгэлийн чанарыг химийн индикаториор өдөр бүр, биологийн индикаториор улирал бүр хянана.

7.4. Халдвартай хог, хаягдлын устгал

7.4.1. Халдвартай хог хаягдлыг зөөвөрлөдөг сав нь дахин хэрэглэх зориулалттай, шингэн нэвтрүүлдэггүй, бат бөх таглаатай байна. Халдвартай хог хаягдлыг зөөвөрлөж ашигласны дараа халдвартгүйжүүлж цэвэрлээд дахин хэрэглэнэ.

7.4.2. Үр үүсгэдэггүй нянгийн халдвартай материалаар халдааж, задлан шинжилгээ хийсэн амь сорьцын амьтан болон хоривчийг 24 цаг, үр үүсгэдэг нянгийн халдвартай материалаар халдвартгүйтгэлийн тохирсон уусмалд байлгасны дараа бүрэн халдвартгүй болсонд тооцно.

7.4.3. Шинжилгээнийүед гарсан хог, хаягдлыг хийх нүх нь 2 м-ээс доошгүй гүнтэй бөгөөд таг нь зайд завсаргүй, бороо, үерийн ус орохогооргүй байна.

7.4.4. Хог, хаягдлын цэг нь салхины доод талд байрлалтай, хаалт, хамгаалалттай, таних тэмдэг тавьсан байна.

7.4.5. Хог хаягдлыг бүрэн халдвартгүйтгэсний дараа нүхэнд хийж, хог хаягдал нүхний амсараас доош 50 см-ээс багагүй дүүрсэн үед нүхийг халдвартгүйтгэж, шороогоор дарж булна.

8. БИО АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛДЛҮҮД:

8.1. Мэрэгч амьтад, гадны шимэгчийг цуглуулах, тээвэрлэх, хадгалах

8.1.1. Голомтот нутагт амьтан судлал, шимэгч судлалын шинжилгээнд ажиллаж буй биологич, анчин, лаборант, жолооч нар тухайн цаг уурт тохирсон, дулааны болон хүйтний улиралд өмсөх хөдөлмөр хамгааллын 2-3 ээлжийн хувцас, хэрэглэл, эм, халдвартгүйтгэлийн бодисоор хангагдсан байхаас гадна хувийн хамгаалах хэрэгсэлийг зааврын дагуу хэрэглэнэ.

8.1.2. Байгалийн голомттой нутгаас шинжилгээ судалгаа, туршилтын ажлын зориулалтаар олборлосон сээр нуруутай амьтад болон цус сорогч үе хөлтнийг

халдвартайд тооцно.

8.1.3. Байгалийн голомттой нутгаас мэрэгчид олборлох, гадны шимэгчид цуглуулахад ашиглах багаж, хэрэгслийг (хавх, занга, гудруул, түүз, хуруу шил, уут, хямсаа...г.м) тохирсон битүү саванд хийж авч явна.

8.1.4. Хавхаар олзворлосон амьтан үхээгүй тохиолдолд урт хямсаа буюу бахиар хүзүүгээр нь хавчиж үхүүлэн нэг бүрчлэн даавуун уутанд хийж уутны амсрыг нийлүүлэн татаж бариад 2-3 давхарлан нугалж бүчээр нь сайтар уяна. Даавуун ууттай амьтныг нэг бүрчлэн эсвэл хэд хэдээр нь ус үл нэвтрэх уут эсвэл хайрцганд хийнэ. Олборлосон амьтад бүрт дагалдах бичиг үйлдэж уутны амсарт уясан байна.

8.1.5. Амьтан болон шимэгч олборлоход ашигласан багаж хэрэгслийг бүрэн халдвартгүйтгэж тусгайлсан байранд хадгална.

8.1.6. Амьдаар нь олборлосон амьтдыг төмөр хоривчинд хийж, шинжилгээнд оруулах хүртэл тусгай зориулалтын тагтай, халдвартгүйтгэл хийх боломжтой бороо, үерийн ус орохооргүй нүхэнд хадгална.

8.1.7. Байгалийн голомтот нутгаас олборлосон мэрэгч, амьтдын чихмэл хийхэд амь сорьцын лабораторит эсвэл тусгай зориулалтын байранд III зэрэглэлийн өмсгөлтэй ажиллана. Чихмэл хийх амьтныг 0.2%-ийн жавелионы уусмалд 120 минут, амьтдын арьсыг 10%-ийн формалины уусмалд 30 минут, амьтны толгойг формалинд хийх буюу буцалгаж халдвартгүйтгэнэ. Чихмэл хийх үед амны хаалт, нүдний шил хэрэглэнэ.

8.1.8. Бусад байгууллагууд нь байгалийн голомттой нутгаас сээр нуруутан болон цус сорогч үе хөлтнийг олзворлох, шинжилгээ судалгааны ажлыг явуулахдаа Зоонозын өвчин судлалын байгууллагын зөвшөөрлөөр, тэдний хяналттай гүйцэтгэнэ.

8.1.9. Судалгаа, туршилтын зориулалтаар амьтдыг олборлох, дээжлэх асуудлыг шинжилгээний ангийн ахлагч хариуцаж, энэхүү ажилд оролцогчдод халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар урьдчилан танилцуулсан байна.

8.1.10. Судалгааны зориулалтаар барьсан амьтдыг ажиглах байранд 14-30 хоног ажиглана.

8.1.11. Ажиглалтад байгаа амьтдаас үхсэн тохиолдолд хамт байсан амьтдыг алж шинжилгээ хийж, тор хоривчийг халдвартгүйтгэж цэвэрлэнэ.

8.1.12. Амьтан хадгалах ажиглах байр, инсекторыг ажил дууссаны дараа битүүмжлэн лацдана.

8.1.13. Ажиглалтад байгаа мэрэгч амьтад, инсекторт байгаа гадны шимэгчдийг халдварын сэргийлэлт, хяналтын багийн зөвшөөрлийг үндэслэн байгууллагын даргын бичгээр үйлдсэн шийдвэрээр бусад байгууллагад шилжүүлж болно.

8.1.14. Ажиглах байр, инсекторт байгаа үе хөлтөн, шавж, амьтдыг олборлосон, цуглуулсан он, сар, өдөр, ажиглалтанд байлгасан хугацаа, тэдний хөдөлгөөн, ажлын үр дүнг тусгай баталсан бүртгэлд тэмдэглэнэ.

8.1.15. Цуглуулсан гадны шимэгчийг (хачиг, бөөс, бүүрэг) амсрын дотор талыг нь вазелин эсвэл глицеринээр тосолсон хуруу шилэнд хийж, сайтар бөглөөд, хуруу шилнүүдийг даавуун эсвэл нийлэг дайзанд байрлуулна.

8.1.16. Лабораторийн шинжилгээнд шилжүүлэх шимэгчдийг бөглөөтэй хуруу шилэн (хачиг, бөөс, бүүрэг хийсэн хуруу шилний амсрыг бөглөхдөө дотор талыг вазелин эсвэл глицеринээртосолсон)-д хийж, химийн бодисоор унтуулсан байна.

8.2.Лабораторийн халдвар хамгаалал, био аюулгүйн шаардлага

8.2.1. Биологийн аюулын II ба түүнээс дээш түвшний эмгэгтөрүүлэгч бичил биетнүүдтэй ажилладаг лабораторийн хаалган дээр биологийн аюулыг анхааруулсан олон улсын тэмдгийг байрлуулна.

Зураг 3. Лабораториудын хаалганд байрлуулах био аюулын анхааруулга тэмдэг



Биологийн
халдвартай

Гадны хүн орохыг
хориглоно

Биологийн аюулгүйн түвшин.....
Хариуцсан ажилтан,
Осол гарахад дуудах утас,
Ажлын утасны №,
Гэрийн утасны №

Хариуцсан ажилтны зөвшөөрлөөр орохыг зөвшөөрнө.

8.2.2. Лабораториудын өрөө, боксуудын байршил, зориулалтыг харуулсан бүдүүвч зургийг хонгилд ил байрлуулна.

8.2.3. Халдвартай хэсэгт гадны хүн орохыг хориглосон таних тэмдэг тавина.

8.2.4. Лабораториудад хөтлөгдөх бүх төрлийн анхан шатны бүртгэлүүдийн хуудас бүрийг дугаарлаж тухайн тасаг эсвэл байгууллагын тамгыг дарж баталгаажуулна.

8.2.5. Лабораторийн шинжилгээнд хэрэглэгдэж байгаа эд зүйлс бүрэн хаягтай байна.

8.2.6. Лаборатори, боксуудад халдвартай ба сэжигтэй материалыг 2-оос доошгүй ажилтан шинжилж, дэглэмийн мөрдөлтөнд харилцан хяналт тавьж ажиллана.

8.2.7. Лабораторит хийгдэх ажлын бэлтгэлийг лаборант бүрэн хангасан байна.

8.2.8. Халдвартай болон сэжигтэй материалыг суулгах петрийн аяга, хуруу шил, бусад саван дээр тухайн материалын болон өсгөврийн нэр, үндсэн бүртгэлийн дугаар, он, сар, өдөр зэргийг зориулалтын үзгээр тодорхой бичнэ.

8.2.9. Халдвартай болон сэжигтэй материал, нянгийн өсгөврийн суулгацтай петрийн аягыг бээлийтэй гараар З ширхэгээс илүүгүйгээр, хуруу шилийг зориулалтын тавиурт байрлуулан лаборатори, боксын дотор зөөвөрлөж болно.

8.2.10. Халдвартай болон сэжигтэй материал, нянгийн өсгөврийг лабораториудын хооронд шилжүүлэхдээ тагтай битүү саванд хийж, хамгаалах III

зэргийн өмсгөлтэй хоёроос доошгүй ажилтан их эмчийн хяналт дор зөөврөлнө.

8.2.11. Амь сорьцын лабораторит ажиллах ажилтнуудын хийх ажилбар, ажилласан сар, өдөр, цаг, минутыг нарийн тэмдэглэсэн бүртгэл хөтөлж, гарын үсэг зуруулна.

8.2.12. Халдвартуулсан амь сорьцын амьтныг шилэн болон төмөр хоривчинд хийж, агаар орох нүхтэй тагаар таглана. Халдвартуулсан сорьцын нэр, дугаар, тун хэмжээ, он сар, өдөр, халдварт хийсэн ажилтнуудын нэрсийг тусгасан хаягийг хоривч дээр наасан байна.

8.2.13. Халдвартай амьтныг хооллох, арчлахдаа өөр хоривчид түр хийж, хоривчийг халдваргүйтгэж цэвэрлэсний дараа уг амьтнаа буцаан хийнэ. Түр хэрэглэсэн хоривчийг тухай бүр халдваргүйтгэнэ.

8.2.15. Амь соръцын лабораторит ажил дууссаны дараа байнгын болон эцсийн халдвартай тэмдэглэл хөтөлнө.

8.2.16. Лабораторийт ажилд боксын ширээн дээрх халдвартай материалыг хурааж дулаан тогтоогуур, хөргөгчид хийж лацдан, ажилбарт хэрэглэсэн бүх багаж, хэрэгсэл, ширээг халдвартайтгэнэ.

8.2.17. Лабораториос гарах халдвартай болон халдваргүй хог хаягдал, халдваргүйтгэл, ариутгал болон лабораторийн шинжилгээ, судалгаанд хэрэглэгдэж буй бодис, урвалж, оношлуурын хангарт, хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлт нь хяналттай байна.

8.2.18. Лаборатори, боксуудын тоног төхөөрөмж, агаараас дотоод халдвартын сорьц улиралд нэгээс доошгүй удаа авч, хяналтын шинжилгээ хийнэ.

8.2.19. Өртөлтийн дараах анхны тусlamж үзүүлэх эмийн санг бэлэн байлгах ба эм бэлдмэлийн хүчинтэй хугацаа, нөхөн хангарт, бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгана.

Хүснэгт 4. Өртөлтийн дараах сэргийлэлтийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХОРСОЛЖИЛТ ХАСАНТ				
№	Эмийн нэрс	Хэмжих нэгж	Тун хэмжээ	Тоо ширхэг
1	Нүдний дусаалга, түрхлэг (антибиотик)	фл	5%	1
2	Доксациклин	таб	0.5	10
3	Цифазолин, цепрофлоксацин	фл	сая	3
4	Натри хлорид 0.9%	амп	2 мл	10
5	Вирусын эсрэг бэлдмэл	хайрцаг	шах	1
6	Өвчин намдаах, халуун бууруулах бэлдмэл	таб	0.5	10
7	Нүдний дусаагуур	ширхэг	1	1
8	Тамедины уусмал	фл	0.7%	1
9	Ариун бинт	ширхэг	1	1
10	Ариутгасан хөвөн	гр	50	1
11	Этилийн спирт	мл	75	1
12	Йод	мл	50	1
13	Ариун нэрмэл ус	мл	100	1
14	Шархны наалт	хайрцаг	50	1
15	Хямсаа	ширхэг	1	1
16	Нэг удаагийн тариур	гр	3	2
		гр	5	2

Тайлбар: Тухайн лабораторит ажилладаг үүсгэгчийн зүйл, онцлогийг харгалзан тохирох антибиотикийг сонгоно.

8.3. Зарим эрсдэлтэй ажилбарыг гүйцэтгэхэд баримтлах био аюулгүй ажиллагаа

Шинжлэгдэхүүн авахаас эхлээд шинжилгээний эцсийн үр дүн гарах хүртэл гардан үйлдлийн стандарт ажлын зааврыг (САЗ)-ыг баримтлах, багаж, тоног төхөөрөмж, урвалж бодис, оношлууртай зөв харьцах ур чадварыг эзэмших нь лабораторийн нөхцөлд тохиолдож болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх, хамгаалахад чухал ач холбогдолтой.

8.3.1. Сорьц хүлээн авах

8.3.1.1. Лабораторийн шинжилгээнд ирүүлсэн халдвартай болон сэжигтэй материал, өсгөвөр омгийг лабораторит хүлээн авахдаа томилогдсон тархвар судлагч, лабораторийн эмч, лаборант нар хүргэгчийг байлцуулан задалж, тусгай маягтыг хөтөлнө.

8.3.1.2. Халдвартай болон сэжигтэй материалыг лабораторийн (онош зүйн, амь сорьцийн) БАК дотор, халдвартай зүйлийн тээвэрлэлтийн нөхцөл,

битүүмжлэл, лацны дугаар, агуулсан савны бүрэн бүтэн байдал, хүргүүлсэн материалын нэр төрөл, тоо хэмжээ, материал асгарч, задарсан эсэх зэргийг нягтлан, дагалдсан бичиг баримттай нэг бүрчлэн тулган үзэж хүлээн авсан акт үйлдэнэ. Материалуудыг холбогдох анхан шатны маягтуудад бүртгэнэ.

8.3.2. Соруур (пипетка)-тай ажиллах

8.3.2.1. Автомат тохируулга бүхий хуванцар соруурыг ашиглах явцад тохирсон хошууг хэрэглэнэ.

8.3.2.2. Шилэн соруурын төгсгөлд хөвөн бөмбөлгөн чигжээс хийнэ. Соруурын үзүүрээс дуссан халдвартай материал тархахаас сэргийлж, ажлын гадаргуу дээр шингээгч материал дэвсэж, дараа нь бусад халдварласан материалтай хамт устгана.

8.3.2.3. Соруураас дуссан зүйлийг цаасанд шингээх, соруур дахь үлдэгдлийг хүчээр үлээлгэж гаргах, халдвартай зүйл агуулсан шингэн рүү соруураар хий үлээх, халдвартай материалыг пипеткээр сорох, буцааж үлээх замаар холих зэрэг үйлдлийг хийж болохгүй.

8.3.2.4. Хагардаггүй саванд хийсэн халдвартайтгэлийн уусмалаас халдвартай соруураар болгоомжтой соруулаад, далд ортол нь хийж, бүрэн халдвартайжтэл нь хангалттай хугацаанд байлгана. Соруурын савыг биологийн аюулгүй кабинетийн дотор нь байрлуулна.

8.3.2.5. Резин бөглөөтэй савнаас материал авахдаа зүүгээр хатгаж соруулж авахаас зайлсхийж, бөглөөг онгойлгох тусгай төхөөрөмжөөр онгойлгосны дараа пипеткээр ажиллана.

8.3.3. Хурилдуур

8.3.3.1. Биологийн аюултай, халдвартай сэжигтэй материалыг хурилдуурдаа хамгаалалттай, тусгай сагтай хурилдуур сонгон ашиглаж, БАК-д ажиллуулна.

8.3.3.2. Хурилдуурын хуруу шил болон хурилдуурт ашиглах шинжлэгдэхүүний савны бүрэн бүтэн байдлыг шалгаж, эргүүлдэг бөглөөгөөр эсвэл нягт резин бөглөөгөөр сайтар таглана. Хуруу шил болон савнуудыг хурилдуурын

үүрнүүдэд ижил жинтэй байхаар зөв харьцаагаар байрлуулах бөгөөд хоосон хуруу шилийг тэнцвэржүүлэгчээр ашиглах тохиолдолд нэрмэл ус буюу спирт (70 хувийн пропанол) хэрэглэнэ. Хурилдуур доторх хуруу шил зэрэг зүйлсийг бүрэн харж болохоор түвшинд байрлуулна.

8.3.3.3. Хурилдуурын роторын дотор талд толбо буюу өнгөр үүссэн эсэх, зэв эсвэл цууралт үүссэн эсэхийг тогтмол шалгана. Долоо хоног тутамд ротор болон бусад хэсгийг тосолно.

8.3.3.4. Хурилдуурдах ажиллагааны үед тагийг хааж, хурилдуурдах ажиллагаа бүрэн зогсооны дараа нээнэ. Хамгаалалтын тагийг байнга ашиглана.

8.3.3.5. Ротор, үүр, хурилдуурын аяга зэргийг хэрэглэсний дараа, халдвартай зүйл асгарсан тохиолдол бүрт хурилдуурыг халдвартгүйтгэнэ.

8.3.4. Няцлагч (гомогенжуулагч)-ийн таглаа, аяга болон шилнүүд нь хагарч эмтрээгүй, таглаа нь тохирсон, жийргэвч нь нягт байна. Няцлагч, сэгсрэгч, соникатор зэргийг ажиллуулах үед доторх даралт нь ихэсдэг тул бат бэх тунгалаг хуванцар хайрцаар бүрсэн сав хэрэглэнэ. Ажилбарын төгсгөлд савыг БАК дотор нээж, доторх хаягдлыг битүү саванд цуглуулж, дараа нь автоклавдаж, устгана.

8.3.5. Өсгөвөр омог, халдвартай материал хадгалдаг лабораторийн хөргөгч, хөлдөөгч, гүн хөлдөөгчийн хаалган дээр биоаюулгүйн тэмдэг байрлуулж, тэдгээрийн хэмийн заалтыг хянаж, ажил дууссны дараа лацдаж битүүмжилнэ. Хадгалагдаж буй материалын нэр, хугацааг савны гадна талд гаргацтай бичиж, устгасан эсвэл шилжүүлсэн тохиолдолд холбогдох бүртгэлийг хөтөлнө. Хөргөгчүүд, хуурай мөстэй савыг цэвэрлэхдээ зузаан резинэн бээлий, нүүрний хамгаалалт зүүх бөгөөд цэвэрлэгээ дууссаны дараа дотор талыг нь халдвартгүйтгэнэ.

8.3.6. Хурц үзүүртэй зүйл болон шилэн эдлэлийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, эмтэрсэн, цуурсан, хагарсан гэмтэлтэй эдлэлийг тухай бүр солино. Хурц үзүүртэй багажтай ажиллахдаа хатгуулах, эсгэгдэх, гэмтэхээс сэргийлнэ. Тариурын зүүг соруурын оронд ашиглаж болохгүй. Нэг удаагийн тариурын зүүг гэрэнд нь буцааж хийлгүй зориулалтын саванд хийж, устгана.

8.3.7. Хуурайшуулсан материал агуулсан ампулыг шингэн азотод хадгалахыг хориглодог, ялангуяа цуурсан эсвэл дутуу гагнасан ампулыг шингэн азотоос гаргах явцад задрах, тэсрэх аюул үүсч болно. Маш нам хэмд зайлшгүй хадгалах шаардлагатай бол шингэн азотын дээд талын хийтэй хэсэгт хадгална. Нам хэмтэй камер эсвэл хуурай мөсөнд хадгалж болно. Нүдний шил, бээлий өмсөж туншилыг хадгалагчнаас гаргаж гадна талыг халдвартгүйжүүлнэ.

8.3.8. Ампулыг нээхэд агаарын огцом тулхэлтийн нөлөөгөөр хуурайшуулсан материал агаарт цацгадах аюултай тул заавал БАК дотор нээнэ. Ампулын гадна талыг халдвартгүйтгээд дээд хэсгийг спиртээр норгосон хөвөнгөөр таглан жийрэглэн барьж, хөрөөдсөн хэсгээр болгоомжтой хугална. Шингэлэх уусмалыг хөөсрүүлэхгүй ханыг дагуулан аажуухан хийнэ.

8.3.9. Гадны шимэгчдийн зүйлийг тодорхойлох, нухаж булинга бэлдэх, тэжээлт орчинд суулгац хийхдээ доор нь халдвартгүйтгэлийн бодис шингээсэн даавуу /марль/ дэвснэ. Хачиг, хувалзаас булинга бэлтгэхдээ тэдгээрийг ууранд хийж, петрийн аяганы таг эсвэл том шилэн юулүүрээр халхлан бариад хайчлаж жижиглэнэ.

8.3.10. Петрийн аяганы тагны голд тавиур шилийг тавьж ус дусаан гадны шимэгчээ байрлуулж, дээр нь бурхүүл шил тавьж бичил харах бөгөөд хэрэглэсэн бүх зүйлийг халдвартгүйтгэлийн уусмалд хийнэ.

8.4. Лабораторит ажиллахад хориглох зүйл

8.4.1. Лабораторийн эмч, мэргэжилтэн ажилтан нь гартаа шархтай, эмнэл зүйн зовиуртай үед халдвартай болон сэжигтэй материалтай ажиллах

8.4.2. Халдвартай ба сэжигтэй материалтай ажилладаг хэсэг рүү хамгаалах өмсгөлгүй буюу дутуу өмсөж орох, үсийг ил гаргах, оймсгүйгээр шаахай, усны гутал өмсөх

8.4.3. Лаборатори болон ариутгал халдваргүйтгэлийн өрөөнд шинжилгээний материалыг шилэн гуурсаар амаараа сорох, хаяг шошгыг долоох, халдвартай материал болон эмгэгтөрүүлэгч бичил биетэнтэй ажиллах явцдаа нүүр, арьс салстдаа бээлийтэй гарaa хүргэх, нүд, амаа арчих, нухах зэрэг үйлдэл хийх

8.4.4. Нэг лабораторит өөр өөр төрлийн шинжилгээ, судалгааны ажил, мал амьтны болон хүний шинжлэгдэхүүнийг нэг дор хамт шинжлэх

8.4.5. Зоонозын өвчин үүсгэгчийн амьд өсгөвөр омог, халдвартай материалыг эмчилгээний бэлдмэлүүд, оношууртай нэг хөргөгчид хадгалах

8.4.6. Захиалга, зөвшөөрөлгүйгээр амьд омгийн сангаас өсгөвөр, омгийг бусад лабораториудад шилжүүлэх, гаргах

8.4.7. Халдвартын сэргийлэлт, хяналтын багийн зөвшөөрөлгүйгээр ажлын бус цагаар лабораторит ажиллах

8.4.8. Хуурайшуулсан өсгөвөр болон оношуур, урвалж бүхий ампулыг цохиж хагалах

8.4.9. Зүү бүхий тариурыг пипеткийн зориулалтаар ашиглах

8.4.10. Бээлийтэй гарцаар компьютерийн гар, телефон утас, бичгийн хэрэгсэл, шинжилгээний болон бусад хөтлөгдвэл зохих бүртгэлтэй харьцах

8.4.11. Шинжилгээ судалгааны ажил дууссаны дараа бэхжүүлээгүй наац, халдвартай болон сэжигтэй материалтай петрийн аяга, хуруу шил, бусад сав зэргийг ил тавих, орхих

8.4.12. Хамгаалах өмсгөлтэй халдвартай ба сэжигтэй материалтай ажилладаг хэсгээс гарах, тухайн хамгаалах өмсгөлийг өөр лабораторит өмсөх ажиллах, хамгаалах өмсгөлтэй лабораториос гадуур явах

8.4.13. Халдвартай болон сэжигтэй материалтай ажилладаг хэсэгт тамхи татах, ус уух, юм идэх, бохь зажлах

8.4.14. Дуу шуугиан гаргах, хөгжим тоглуулах зэргээр хүний анхаарал сарниулах, айлгаж цочоох, ажлын байрнаас гадагш дуудах

8.4.15. Хувийн эд зүйл, хувцас, хоол хүнсний зүйл, бичгийн хэрэглэл, ном, гар утас зэргийг лабораторит оруулж ашиглах

8.4.16. Лабораторийн хөргөгч, термостат, өрөө зэргийг лацдахгүй орхих, лабораторийн хаалгыг нээлттэй байлгах

8.4.17. Лабораторийн хог хаягдлыг бохирын нүхэнд халдваргүйтгэлгүйгээр хийх

8.4.18. Гал түймэр гарсан үед өсгөврийг зөөвөрлөх

8.4.19. Ажлын талбайд лабораторийн бус зүйл хадгалах, гоо сайхны зүйл хэрэглэх, контакт линзтэй харьцах, тамхи татах, уух, идэх зэргийг тус тус хориглоно.

8.5. Лабораторит химийн бодис, гал, цахилгааны аюулгүй байдлыг хангах

8.5.1. Зөвхөн нэг өдрийн хэрэглээнд шаардагдах хэмжээний химийн бодисыг лабораторид хадгалж, бусад нөөцийг тусгай зориулалтын өрөө буюу байшинд хадгална.

8.5.2. Лабораторийн ажилтнуудад галаас сэргийлэх, гал гарсан үед яаралтай арга хэмжээ авах, гал унтраах хэрэгслийг ашиглах талаар сургалт явуулж, галын сэргэмжлүүлэг, гал гарсан үед ажиллах заавар болон гарцыг өрөө тасалгаа, хонгил, гудам бүрт харагдахуйц байрлуулсан байна.

8.5.3. Цахилгааны бүх холболтууд ба тоног төхөөрөмжүүдийг, түүний дотор газардуулга болон хамгаалалтын системийг тогтмол шалгаж, лабораторийн холболтууд хийхдээ богино долгионы болон газардуулгын гал хамгаалагчийг зөв холбооос гадна лабораторийн бүх цахилгаан хэрэгслийг гурван сэрээт залгуур ашиглан газардуулна.

9. БИО ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

9.1.3ХӨ-НИЙ ҮҮСГЭГЧ, ТЭДГЭЭРИЙН ХОРТ БЭЛДМЭЛҮҮДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ТЭЭВЭРЛЭХ

9.1.1. Лабораторийн шинжилгээний явцад илрүүлсэн эмгэг төрүүлэгч бичил биетэн, өсгөврийн талаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 7 хоногийн дотор мэдээлж, нэг сарын дотор шилжүүлж баталгаажуулна.

9.1.2. Цууралт, эмтрэлгүй бүрэн бүтэн хуруу шилэнд (үүсгэгчийн зүйлийн нэр, суулгац хийсэн он, сар, өдрийг тэмдэглэнэ) ташуу савласан тохиорох хатуу тэжээлт орчинд нянгийн өсгөвөр, омгоос 2% суулгац хийж өсгөвөрлөнө. Колонийн морфологи хэвийн, цэвэр ургалттай нян, вирус, риккетсийн үүсгэгч, ургацыг агуулсан эд, эсийг зориулалтын сав (3 савлагаат систем), хайрцагт хөдөлгөөнгүй байрлуулан бүрэн битүүмжилж, хайрцгийг цоожилж лацдана. Хайрцагны гадна талд биологийн халдвартай зүйл гэдгийг тодорхойлсон таних тэмдэг байна.

9.1.3. Үүсгэгчийн ДНХ, РНХ-ийг тусгайлан ялгах, зөөвөрлөхөд зориулсан материал (FTA[□] card г.м)-ыг зааврын дагуу ашиглана.

9.1.4. Нянгийн өсгөвөр, биологийн халдвартай зүйлийг бие хүнээр эсвэл шуудангийн сүлжээгээр хүргэх бөгөөд хүргэх хүн, хугацааны талаар урьдчилан мэдээнэ.

9.1.5. Өсгөвөр, биологийн халдвартай зүйл илэрсэн болон шилжүүлэх талаар орон нутгийн хууль хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

9.1.6. Орон нутгаас өсгөвөр, биологийн халдвартай зүйл шилжүүлэх үед тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газар, (ЗӨС-ын төвгүй аймаг), ЗӨСТ-ийн даргын тушаал, хүлээлцсэн акт, өсгөврийн паспорт зэргийг хамт ирүүлнэ.

9.1.7. Шилжүүлсэн өсгөвөр, биологийн халдвартай зүйлийн эх материал, бусад суулгацын үлдэгдлийг устгаж бичиг баримтыг бүрдүүлнэ.

9.1.8. Хэрэв энгийн дэглэмтэй лабораториудад шинжилгээний ажлын явцад БГХӨ-ний II- III түвшний нянгийн өсгөврийг илрүүлсэн тохиолдолд шинжилгээг зогсоож, орон нутгийн эрүүл мэндийн газарт мэдээлж, ЗӨС-ын төвд хүргэнэ. Тухайн лабораторит эцсийн халдвартайг хийнэ.

9.1.9. Өсгөвөр, биологийн халдвартай зүйлийг хүргэхээр томилогдсон ажилтан гэнэтийн шалтгаанаар хүргэж чадахгүй болсон тохиолдолд тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газар (ЗӨС-ын төвгүй аймаг), аймгийн ЗӨСТ-д мэдэгдэж өсгөврийг хамгаалалтад авахуулна.

9.2. 3ХӨ-НИЙ АМЬД ҮҮСГЭГЧ, ТЭДГЭЭРИЙН ХОРТ БЭЛДМЭЛҮҮДИЙГ ХАДГАЛАХ

9.2.1. Дэглэмийн байгууллагад эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, сургалтын зориулалтаар II-IY ангилалд хамаарах үүсгэгчдийн цуглувалга бүхий амьд омгийн сан (АОС)-тай байж болно.

9.2.2. Нарийн мэргэжил эзэмшиж, 5-аас дээш жил ажилласан их эмч, лаборант, ариутгагчийг захирлын тушаалаар томилон АОС-д ажилуулна.

9.2.3. Амьд омгийн санд өсгөвөр, омгийг хүлээн авах, цуглуулгыг хадгалах, шилжүүлэх, баяжуулах, хамгаалах, тайлагнах, бичиг баримтыг бүрдүүлэх зэрэг гүйцэтгэнэ.

9.2.4. АОС-ийн харьяалах алба, нэгжийн дарга, эрхлэгч нарын зөвшөөрлийг үндэслэн өсгөвөр омгуудыг хувилах, олгох ажиллагааг гүйцэтгэж, тусгай бүртгэлд тэмдэглэл хийнэ.

9.2.5. Өсгөврийг хувилж авах ажилтан нь З хоногийн өмнө АОС-нд захиалгаа өгч, хүлээж авах цаг хугацааг тохирсон байна.

9.2.6. АОС-аас шилжүүлэн авсан өсгөвөр омгуудын хадгалалт, хамгаалалт, бүртгэл судалгааг тухайн хүлээн авсан лабораторийн эмч, лаборант нар хариуцаж, эдгээр өсгөврийг өөр байгууллага, тасаг лабораторит шилжүүлэхийг хориглоно.

9.2.7. АОС-аас хувилж авсан өсгөвөр, омгуудыг захиалж авсан лаборатори нь судалгааны ажлаа дуусангуут зохих журмын дагуу устгах бөгөөд АОС-ийн эмч хяналт тавина.

9.2.8. Амьдрах чадваргүй болсон буюу устгах өсгөврүүдийг захирлын тушаалаар томилогдсон комисс устгахад оролцож, хяналт тавихын зэрэгцээ холбогдох бичиг баримтыг бүрдүүлнэ.

9.2.9. Нян, вирусийн цэвэр өсгөвөр, тэдгээрийн хорт бэлдмэлүүдийг тавьж олгох, хүлээн авах журмын биелэлтэнд тархвар судлагч нар болон дэглэмийн комиссын гишүүд, тухайн нэгжийн эрхлэгч нар хяналт тавина.

9.2.10. Биологийн аюулын III-IV ангилалд хамаарах нян, вирусын өсгөврийг хилийн чанадад шилжүүлэх, хилийн чанадаас хүлээн авах ажлыг Монгол улсын хэмжээнд мөрддөг эрх зүйн актыг үндэслэн гүйцэтгэнэ.

9.2.11. Үндэсний Төвийн халдвартын сэргийлэлт, хяналтын багийн хурлын тэмдэглэлийг үндэслэн байгууллагын удирдлагын шийдвэрээр биологийн аюулын III, IV түвшингийн бичил биетэнтэй ажиллах туршилт, судалгааны ажлын зөвшөөрлийг олгоно.

10. ХҮНИЙ ӨВЧНИЙ ГОЛОМТОД МӨРДӨХ БИОАОУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДЭГЛЭМ:

10.1. Хүний өвчний голомт дахь хүн амын эрүүл мэндийн хяналт

10.1.1. Зоонозын өвчний голомтод байгаа хүн амын болон тарваган тахлын уушгины хэлбэрээр өвчилсөн хүний хоёрдогч хавьтлуудын эрүүл мэндийг гэрээр хянах ажлыг өрхийн эмч нар гүйцэтгэнэ.

10.1.2. Голомт үүссэн нутаг дэвсгэрт байгаа айл өрхөд хяналт тавих эмч нь хамгаалах өмсгөл болон халдвартын бодис зэрэг зүйлээр хангагдсан байна.

10.1.3. Гэрээр эргэх явцад өвчтэй буюу сэжигтэй хүн илэрвэл эмнэлгийн штабт яаралтай мэдээлж, холбогдох хариу арга хэмжээг авна.

10.2. Эмчлэх, тусгаарлах, ялан оношлох эмнэлгийн биоаюулгүй ажиллагаа

10.2.1. Эмнэлгүүдийн зохион байгуулалтад баримтлах дэглэм

10.2.1.1. Өвчтөнийг халдвартын тасаг эсвэл тусгай боксад хэвтүүлэн, халдвараас хамгаалах дэглэмийг чанд мөрдөж ажиллана.

10.2.1.2. Өвчтөний хавьтлуудыг тусгаарлах тасагт хэвтүүлэн оношийг

яаралтай тодруулан, холбогдох эмнэлэгт шүлжүүлэн эмчилнэ.

10.2.1.3. Дээрхи тасгууд нь тус тусдаа байрлах бөгөөд халдвартай, халдвартай 2 хэсэгтэй байна.

10.2.1.4. Эмнэлгийн халдвартай хэсэгт: хүлээн авах, эрчимт эмчилгээний, өвчтөний палат, халдвартайтгэлийн гэх мэт өрөө тасалгаанууд багтана.

10.2.1.5. Өвчтөн хэвтүүлэх бокс өрөөг нэг чиглэлийн урсгалтай зохион байгуулна.

10.2.1.6. Өвчтөн хүлээн авах хэсэгт эмчилгээ, үйлчилгээ хийхээс гадна өвчтөний хувцсыг халдвартайтгэлд бэлдэж тавина.

10.2.1.7. Өвчтөн хэвтүүлэх, хавьтлуудыг тусгаарлах, ялгах эмнэлэгт ажиллагсадад зориулсан (гадуур хувцас тайлах, хамгаалах хувцас өмсөх, ариун цэврийн нэвтрэх) өрөө байна.

10.2.1.8. Өвчтөн эмчлэх, тусгаарлах, ялан оношлох эмнэлэг тус бүрт хоол түгээх цэг байгуулна.

10.2.1.9. Зориулалтын боксгүй үед өвчтөний өрөөнд нь хөтөвч тавьж өгнө.

10.2.1.10. Хавьтлуудаас эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл уг хавьтлыг халдвартын эмнэлэгт шилжүүлэн оношийг яаралтай тогтоож, хамт байсан хүмүүсийг өөр байранд шилжүүлж, тусгаарлах хугацааг тухайн өвчиний нууц үеийн хугацаагаар сунгаж дахин тусгаарлана.

10.2.1.11. Өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх, тусгаарлах, ялан оношлох эмнэлэг, ажиглах байр нь цэрэгжүүлсэн харуул хамгаалалтад ажиллана.

10.3. Эмнэлэг дэх халдварт хамгааллын дэглэм

10.3.1. Өвчтөн болон тэдгээрийн хавьтлуудыг шилжүүлэх, тээвэрлэх асуудлыг тархвар судлалын баг зохион байгуулна.

10.3.2. Тарваган тахал, холерын хатуу хөл хорионы бүсэд ажиллагсад эмнэлгийн хяналтад байх бөгөөд хөл хорионы бүсээс гаргах хугацааг тархвар судлалын баг шийдвэрлэнэ.

10.3.3. Өвчтөнийг зөөвөрлөсөн тээврийн хэрэгслийг тусгай талбайд халдвартайтгэнэ.

10.3.4. Холерын голомтод ажиллагсадад 1 удаа, холерын үүсгэгчтэй буюу сэжигтэй материалтай ажиллагсадад 10-14 хоногт 1 удаа вибрион хадгалагчийг илрүүлэх шинжилгээ хийнэ.

10.3.5. Өвчтөнийг эмнэлгээс гаргахын өмнө халдвартай байдлыг баталгаажуулах зорилгоор сорьц авч нян, вирус, эгэл биетний шинжилгээ хийнэ.

10.3.6. Өвчтөний эмнэлэг, тусгаарлах тасаг, ялгах эмнэлэгт байнгын, өвчтөн эмнэлгээс эдгэрч гарсан болон нас барсаны дараа өрөөнд эцсийн халдвартайтгэл хийнэ.

10.3.7. Өвчний голомтод ажиллагсадын эрүүл мэндэд хяналт тавих бөгөөд ажиллагсадаас халуурсан, булчирхай цочсон, хodoод гэдэсний хямрал зэрэг шинж тэмдэг илэрвэл тусгаарлах тасагт хэвтүүлэх ба хавьтлыг тухайн хүний шинжилгээний хариу гартал хяналтад байлгаж шийдвэрлэнэ.

10.4. Ажиглах, ялан оношлох ажиллагаанд мөрдөх дэглэм

10.4.1. Ажиглах байранд оруулахын өмнө халуунтай буюу хodoод гэдэсний хямралтай хүмүүсийг илрүүлэх зорилгоор эмчийн үзлэг хийж, эрүүл хүмүүсийг оруулна.

10.4.2. Ажиглах байранд оруулах хүмүүсийн хяналт тогтоох хугацаа ижил

байна.

10.4.3. Ажиглалтад байсан хүмүүсийг хугацаа дуусмагц уг байрнаас гаргаж эцсийн халдвартгүйтгэл хийсний дараа дараагийн хүмүүсийг оруулна.

10.4.4. Ажиглах байранд халуунтай буюу ходоод гэдэсний хямралтай хүмүүс илэрвэл тэдгээрийг ялган оношлох эмнэлэгт шилжүүлэн тэдэнтэй хамт байсан хүмүүсийг тухайн өрөөнд нь нян судлалын шинжилгээний хариу гартал тусгаарлана.

10.4.5. Ажиглалтад байгаа хүмүүсээс хэн нэг нь тухайн халдвараар өвчилвэл бусад хүмүүсийг тусгаарлаж, энэ өдрөөс ажиглалтын хугацааг шинээр эхлэн тооцно.

10.4.6. Ажиглах байранд тусгаарлалт хангалтгүй байсан бол сүүлчийн өвчтөнийг ялгах эмнэлэгт шилжүүлснээс хойш ажиглалтын хугацааг дахин сунгана.

10.4.7. Ажиглалтад байгаа хүмүүсийг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн ОБШ-ын шийдвэрээр халдвар эсэргүүцэх хариу арга хэмжээнд дайчлан ажиллуулж болно.

10.4.8. Тодорхой бус шалтгаанаар тухайн өвчин төст эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн хүмүүсийг ялгах эмнэлэгт хэвтүүлнэ. Ялгах эмнэлэгт оношийг яаралтай тодруулж, холбогдох эмнэлэгт шилжүүлнэ.

10.4.9. Ялган оношлох тасагт байгаа хүмүүсээс нян судлалын шинжилгээгээр зерэг дүн гарвал ялгах тасгийн өвчтөнийг халдвартын тасаг, боксад хэвтүүлэн, ялгах тасагт хамт байсан хүмүүсийг ялгах эмнэлгийн хяналтад байх хугацааг уг өвчний нууц үеийн хугацаагаар тооцон тусгаарлалтыг шинэчилнэ.

10.5. Цогцост эмгэг судлалын шинжилгээ хийх

10.5.1. Эмгэг судлалын шинжилгээний байр нь гэрэлтүүлэг сайтай, шавьж, амьтан орохооргүй хамгаалагдсан байна. Эмгэг судлалын шинжилгээний байргүй бол дулааны улиралд оршуулах нүхний дэргэд тусгай тавиур бэлдэж цогцост эмгэг судлалын шинжилгээ хийж болно.

10.5.2. Тарваган тахал, боом болон зоонозын бусад өвчнөөр нас барагчийн цогцсыг оршуулах, чандарлах асуудлыг мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн орон нутгийн засаг захиргааны шийдвэрээр төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэж тэмдэглэл хөтөлнө.

10.5.3. Лабораторийн шинжилгээгээр зоонозын өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон бол эмгэг судлалын шинжилгээ хийхгүй байж болно.

10.5.4. Нян судлалын шинжилгээгээр боомын онош бүрэн батлагдсан бол цогцост эмгэг судлалын шинжилгээ хийхгүй байж болно. Боомоор нас барагчийн цогцост хээрийн нөхцөлд эмгэг судлалын шинжилгээ хийхийг хатуу хориглох бөгөөд зөвхөн сорыц дээжлэх асуудлыг мэргэжлийн байгууллага шийдвэрлэнэ.

10.5.5. Цогцос оршуулах үйл ажиллагааг зоонозын халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар баримтлан гүйцэтгэх бөгөөд тархвар судлагч эмч хяналт тавина.

10.5.6. Оршуулгын ажлыг үндэстэн, ястны болон орон нутгийн уламжлалт ёсыг харгалзан үзэж, хүн ам оршин суудаг газраас 15 км-ээс доошгүй зайдай газрыг сонгоно. Цогцсыг гадаад оронд болон өөр нутагт шилжүүлэн оршуулахыг хориглоно.

10.5.7. Шарил тээвэрлэхдээ шингэн нэвтрэхгүй эдийг дэвсэж, халдвартгүйтгэх усмалаар норгосон даавуугаар цогцсыг битүү ороосон байна.

10.5.8. Цогцсыг чандарлаж оршуулахаар бол 2 метр урт, 1 м өргөн, 1,5 метр

гүн ухаж, нүхний нарийн талаас 60⁰-аас доошгүй налуу гаргана. Нүхний ёроолд 80 см-ээс доошгүй зузаантай түлш өрж цогцсоо байрлуулж, цогцосны дээр 1 метр зузаан түлш тавьж 60-70 литр шатахуун асгаж салхин дээрээс нь галтай бамбар (зайнаас) шидэж гал өгнө. Шатах явцад байнгын харуул ажиллуулна. Шатаж дууссаны дараа халдвартгүйтгэлийн бодис цацаж шороогоор булж дарна. Нэг дор хэд хэдэн цогцсыг чандарлах шаардлага гарвал нүхийг зохих хэмжээгээр томосгож ухна.

10.5.9. Хэрэв цогцсыг хайрцаглан оршуулахаар бол хайрцаг нь шингэн нэвтрэхгүйгээр доторлосон байх бөгөөд ёроолд нь хлорын шохойг 10см зузаантайгаар жигд тарааж дэвсэнэ. Халдвартгүйтгэх уусмалаар норгосон даавуугаар цогцсыг битүү ороож хайрцагт байрлуулан дээр нь хлорын шохойг 10 см зузаан хийж таглаад шарилыг нүхэнд байрлуулна.

10.5.10. Оршуулсан шарилыг тодорхой хугацааны дараа дахин шинжлэх шаардлага гарвал тухайн орон нутгийн хуулийн байгууллагын шийдвэрийг үндэслэн тусгай томилогдсон комисс гүйцэтгэж тэмдэглэл хөтөлнө.

10.5.11. Цогцос оршуулах үйл ажиллагаа дууссаны дараа эцсийн халдвартгүйтгэл хийж тэмдэглэл хөтөлнө

11. ХАЛДВАР ХАМГААЛАЛ, БИО АЮУЛГҮЙН ДЭГЛЭМИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

11.1. Халдвартын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагаа

Зоонозын халдвартын хяналт, сэргийлэлтийн үйл ажиллагаанд биоаюулгүйн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төвд 7-9, орон нутагт 3-5 хүний бүрэлдэхүүнтэй халдвартын сэргийлэлт, хяналтын багийг байгууллагын дарга (захирал)-ын тушаалаар томилж, ажиллуулна.

11.1.1. Халдвартын сэргийлэлт, хяналтын багийн үндсэн үүрэг

ХСХ-ын баг нь био эрсдэлийн хүчин зүйлийг тодорхойлж үнэлэх, биоаюулгүйн удирдлага, дэвшүүлж буй бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн жилийн ажлын төлөвлөгөөтэй байна.

11.1.2. Тухайн байгууллагын хэмжээнд дараах баримт бичгийг бүрдүүлж, тэдгээрийн хадгалалт, баяжилтыг хангана. Үүнд:

- Лабораторийн барилга байгууламжийн ашиглалт, инженер техникийн засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийн талаарх тэмдэглэл
- АОС-д хадгалагдаж буй эмгэг төрүүлэгч бичил биетний төрөл, зүйл, тоо хэмжээг тусгасан дэлгэрэнгүй нэгдсэн судалгаа
- Болзошгүй аюул, ослын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- Лабораторийн шинжилгээ, судалгаа, био үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй цацраг идэвхит болон химийн бодисын дэлгэрэнгүй судалгаа
- Лабораторит ашиглагдаж буй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээний хугацаа, чанарыг тодорхой тусгасан судалгаа
- Лабораторийн ажилтнуудын дэлгэрэнгүй судалгаа, эрүүл мэндийн үзлэгийн карт

11.1.3. Дэглэмийн байгууллагын үйл ажиллагаанд биологийн аюул, эрсдэлийн дүн шинжилгээ хийх, хүчин зүйлийг тодорхойлж үнэлэх, бууруулах, үр дүнг

тооцох, баримтлах бодлого чиглэлийг тодорхойлно.

11.1.4. Болзошгүй аюул, гамшигийн үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, бэлэн байдлыг хангахад хяналт тавина.

11.1.5. ХСХ-ын багийн гишүүдэд тасаг, лабораториудыг хуваарилан өгч тусгай хуваариар, доорхи чиглэлээр хяналт шалгалт хийнэ. Үүнд:

- Лабораторийн ажилтны мэргэжлийн ур чадварын байдал,
- Эмгэг төрүүлэгч бичил биетний өсгөвөр, халдвартай материалын шилжүүлэлт, хөдөлгөөн, холбогдох заавар, журмын хэрэгжилт,
- Лаборатори дахь халдвартгүйтгэл, ариутгал, цэвэрлэгээ, хог хаягдлын менежментийн хэрэгжилт,
- Лабораторийн ажилбар эхлэх бэлэн байдал болон ажил дуусах явц, гүйцэтгэх ажилбарууд,
- Лабораторит хөтлөгдөж буй анхан шатны бүртгэл маягт, шинжилгээ, судалгааны тэмдэглэл болон бусад дагалдах бичиг баримт,
- Биоаюулгүй ажиллагаа, биоаюулгүй байдал, техникийн ашиглалт

11.1.6. Шинээр ажилд орж байгаа ажилчдад дэглэмийн зааврыг бие даан судлуулан 3 хоногийн дотор шалгалт авна. Шалгалт авсан ХСХын багийн гишүүн тухайн хүнд зааварчилгаа өгч, хуудсанд тэмдэглэн, халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах зөвшөөрөл олгоно.

11.1.7. Барилга, байгууламжид засвар хийх, өрөө тасалгааны байршил өөрчлөх, эрдэм шинжилгээ, сорил туршилтын ажлыг явуулах бэлтгэл хангах болон ажлын явцад хянаж дүгнэлт гаргана.

11.1.8. Халдвартай ба сэжигтэй материалтай ажилладаг эмч, ажилчдаас жилд 1 удаа дэглэмийн шалгалт авч ажиллах эрхийг баталгаажуулна. Дэглэмийн шалгалтанд 3 удаа хангальгүй дүн үзүүлсэн ажилтныг цаашид ажиллуулах эсэх талаар дүгнэлт гаргаж захиргаанд танилцуулна.

11.1.9. Лабораторийн биоаюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж, ажиллагсдыг дархлаажуулалтад хамруулна.

11.1.10. Эмгэг төрүүлэгч бичил биетнийг ашигласан туршилт, судалгааны ажлыг эхлүүлэхээс өмнө удирдамж, протоколтой танилцан гарч болзошгүй эрсдлийг үнэлэх, зөвшөөрөл олгох, өндөр хоруутай эмгэг төрүүлэгч нянгаар амь сорьцын амьтанд халдварт хийх судалгааны ажлын явцад хяналт тавина.

11.1.11. Яаралтай шинжилгээ хийх зориулалтын лаборатори хүрэлцэхгүй нөхцөлд тухайн байгууллагын нян судлалын болон бусад лабораториудыг ашиглах зөвшөөрөл олгоно.

11.1.12. Тасаг, лабораторит ажлын бус цагаар ажиллахад зөвшөөрөл олгоно.

11.1.13. Байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр лабораториудаас эд зүйл, тоног төхөөрөмж, эм урвалж, оношуулж зэргийг гадны байгууллагад шилжүүлэх үед зохих халдвартгүйтгэл хийлгэж, хяналт тавина.

11.1.14. ХСХ-ын багийн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт, тайланг гаргана.

11.2. ХСХ-ын багийн эрх:

11.2.1. Байгууллагын удирдлага, тасаг, лабораторийн эрхлэгч, нийт эмч, ажилтнуудад дэглэмийн зааврыг баримталж ажиллахыг шаардах, зөрчигчдөд

хариуцлага тооцох саналыг захиргаанд оруулах

11.2.2. ЗХӨ үүсгэгч, халдвартай болон сэжигтэй материалтай ажиллаж байгаа бусад байгууллагын лаборатори, тасагт дэглэмийн зааврыг хэрэгжүүлж буй байдалд хяналт шалгалт хийж, мэргэжлийн дүгнэлт гаргах

11.2.3. Дэглэмийн зааврын шаардлагыг хангаж чадаагүй зөрчилтэй лаборатори, байранд халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах зөвшөөрлийг цуцлах буюу хориглох

11.2.4. Батлагдсан бүртгэлүүдээс гадна шинжилгээ, судалгааны ажилд нэмэлтээр хөтлөгдөх маягт, бүртгэлүүдийн хөтлөлтөд хяналт тавих

11.2.5. Үндэсний Төвийн ХСХ-ын баг нь дэглэмийн байгууллагуудын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах эрхтэй ба ажиллагсдын эрүүл мэндэд хохирол учруулж болохуйц үйл ажиллагааг явуулж осол зөрчил гаргасан, технологи зөрчсөн үед 8 хоног хүртэл хугацаагаар уг тасаг, лабораторийг түр хаах

11.2.6. Үйл ажиллагааны болон дэглэмийн зөрчил гаргаж хаагдсан лаборатори, боксын үйл ажиллагааг хэвийн болсон үед үйл ажиллагааг эхлэх зөвшөөрөл олгох

11.2.7. Урьдчилан сэргийлэх тарилгаас эрүүл мэндийн заалтаар чөлөөлөгдсөн хүмүүсийн ажлын нөхцөлийг удирдлагад тавьж шийдвэрлүүлэх

11.2.8. Өсгөвөр, биологийн халдвартай зүйл болон бусад материалыг лабораторит ажлын бус цагаар хүлээлцэх шаардлага гарсан тохиолдолд зөвшөөрөл олгох

11.2.9. Зоонозын эмгэг төрүүлэгч бичил биетэн, халдвартай болон сэжигтэй материалтай ажиллаж байсан лаборатори, тасгуудыг нүүлгэн шилжүүлэх, засварлах, өөрчлөх, өргөтгөх тохиолдолд зөвшөөрөл олгох

11.2.10. Лабораторид хийгдэх судалгаа, туршилтын ажлын удирдамж, аргачлал, бэлтгэл ажлын хангалтыг шалгасны дараа эхлүүлэх зөвшөөрөл өгөх

11.3. Хөндлөнгийн хяналт

11.3.1. Үндэсний төвөөс дэглэмийн байгууллагуудад био аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын байдал, ХСХ-ын багийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж болно.

11.3.2. Шаардлагатай тохиолдолд Үндэсний төвийн ХСХ-ын баг нь хяналтын байгууллагад хандаж бичгээр санал гарган шийдвэрлүүлнэ.

11.3.3. Лабораторийн биоаюулгүй ажиллагааны хэрэгжилтийг байгууллагын дотоодын болон мэргэжлийн удирдах байгууллагын хөндлөнгийн хяналтаар үнэлүүлж, болно.

12. ЛАБОРАТОРИТ АЖИЛЛАХ ЯВЦАД ОСОЛ ГАРСАН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

12.1. Дэглэмийн байгууллагын эмч, ажилтнууд дэглэмийн осол, зөрчил гаргасан тухай бүр нь нэгжийн дарга, эрхлэгчээр дамжуулан ХСХ-ын баг, байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.

12.2. Халдвартай ба сэжигтэй материалтай ажилладаг эмч ажилтнуудаас өвчний шинж тэмдэг илэрвэл тусгаарлан, лабораторийн шинжилгээгээр оношийг тогтоож, эмчилгээг эхэлнэ.

12.3. Халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах явцад осол гаргаж халдвар байгууллагаас гадагшаа алдагдсан байж болзошгүй сэжиг илэрсэн тохиолдуудад

эрүүл мэндийн удирдах дээд байгууллагуудад яаралтай мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна.

12.4. Дэглэмийн осол, зөрчлийн цар хүрээ, нийгэмд учруулах аюул, тухайн үед ажиллаж байсан үүсгэгчийн биологийн аюулын төвшин зэргийг харгалзан ажилтанд сахилгын арга хэмжээ (сануулах, цалингийн хувиар торгох, тодорхой хугацаагаар албан тушаал бууруулах гэх мэт) тооцох ба байгууллагын удирдлагын хурлаар шийдвэрлэнэ.

12.5. Гаргасан дэглэмийн осол, зөрчлийг нуун дарагдуулсны улмаас байгууллага, улсад хохирол учруулсан буруутай этгээдийг ажлаас нь өөрчлөх буюу хүндрүүлэн үзэх шалтгаантай бол хуулийн байгууллагад шилжүүлнэ.

12.6. Тасаг, лабораториудад гарсан дэглэмийн осол, зөрчил, тархвар судлал болон биоаюултай байдал үүссэн тохиолдолд ХСХ-ын багийн бүрэлдэхүүнээр шалгаж ослын шалтгааныг тогтоож доорхи арга хэмжээг авна. Үүнд:

12.6.1. Амьд бичил биетэн, биологийн халдвартай зүйлтэй ажиллаж байгаад агаарт цацагдсан байж болзошгүй гэж үзвэл сорогч шүүгээ болон биологийн аюулгүй ажиллагааны кабинетыг ажиллуулсан чигээр нь орхин тухайн бокс, өрөөнөөс гарч түүний өмнөх өрөөнд орно. Агаарт цацагдаагүй гэж үзвэл тухайн өрөөнөөс гарахыг хориглоно.

12.6.2. ХСХ-ын багийн 2-оос доошгүй гишүүн хамгаалах I зэргийн өмсгөлтэй тухайн голомтод орж, ослын цар хүрээ, учирч болох хохирлыг урьдчилсан байдлаар тогтооно.

12.6.3. Ослын байдалтай нь бүрэн танилцаад осол гаргагч болон тухайн осол гарсан орчныг нэн тэргүүнд халдвартгүйтгэнэ. Осол гаргагчийн нүд, ам, хамрын салстад тухайн үүсгэгчийн өндөр мэдрэг антибиотикийг яаралтай дусаах болон угаана. Биеийн ил хэсгийг 70°C -ын этилийн спиртээр арчиж халдвартгүйтгэнэ.

12.6.4. Осол гаргах үед өмсөж байсан хувцсыг тайлж халдвартгүйтгэнэ.

12.6.5. Осол гарсан өрөө, тасалгаа, түүнд байгаа багаж тоног төхөөрөмж болон бусад эд зүйлийг уг зааврын хавсралтанд заасны дагуу халдвартгүйтгэнэ.

12.6.6. Ослын улмаас биеийн аль нэг хэсэгт арьс, салстын бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдолд тэр хэсгийг халдвартгүйтгэж, анхны тусламж үзүүлнэ.

12.6.7. Ослын хэмжээ, халдварт судлалын холбогдолыг үндэслэн өвчний нууц үеийг дуустал бүрэн тусгаарлах, сэргийлэх эмчилгээ хийлгэх асуудлыг ХСХ-ын багийн саналыг үндэслэн удирдлага шийдвэрлэнэ.

12.6.8. Дэглэмийн ослын талаар авсан арга хэмжээг байгууллагын удирдлагад тухай бурд нь танилцуулж байна.

12.6.9. Голомт хяналтын шинжилгээнд ажиллаж байгаад осол гаргасан бол тухайн шинжилгээний багийн ахлагч, лабораторийн их эмчид мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна.

12.6.10. Халдвартай материал асгарсан, сав нь хагарсан тохиолдолд даавуу эсвэл шингээгч цаасаар бүтээж, дээр нь халдвартгүйтгэлийн бодис цацаж тодорхой хугацаанд байлгана. Бүтээсэн цаас, даавуу, хагарсан сав, үйрмэгийг өндөр концентраци бүхий халдвартгүйтгэлийн уусмалтай саванд хийнэ. Тухайн гадаргууг халдвартгүйтгэлийн бодисоор арчиж цэвэрлэнэ. Хаягдал хийсэн хогийн саванд уусмал хийж тавина.

12.6.11. Хэрэв чухал бичгийн материал, бүртгэл өртсөн тохиолдолд хатааж,

хамгаалах өмсгөл, хэрэгсэлтэйгээр хуулбарлан авч, өртсөн материалыг халдваргүйтгэлийн уусмал бүхий хаягдлын саванд хаяна.

12.6.12. Хурилдуурыг ажиллуулж буй үед ямар нэг эвдрэл гарвал моторыг унтрааж, нээлгүйгээр хөргөнө. Эвдрэлийн шалтгааныг цаг тухайд нь засварлана. Хуруу шил хагарсан тохиолдолд шилний хэлтэрхийг хямсаагаар бээлийтэй гараар түүж, ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй халдваргүйтгэлийн уусмалд эд анги, шилний хагархай зэргийг авч хийнэ. Хурилдуурын дотор талыг халдваргүйтгэлийн уусмалаар арчиж, норгосон даавуугаар, дараа нь усаар, дахин халдваргүйтгэлийн уусмалаар арчиж, усаар зайлан хатаана. Цэвэрлэгээнд хэрэглэсэн бүх зүйлсийг халдваргүйтгэнэ. Хурилдуурын аюулгүй сагсан дотор хагарсан гэж үзвэл эд ангийг суллан халдваргүйтгэнэ.

12.6.13. Тусгаарлах өрөө, тасагт их эмч, лаборант, сувилагч, асрагч тус бүр нэг цагийн завсарлагатай 6 цагаар ажиллана. 24 цагаар ажиллах шаардлага гарвал байгууллагын удирдлагаас баталсан хуваарийг баримтална.

--ооо--

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 6. сарын 27.-ны өдрийн
16/ дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Үр үүсгэдэг нянгийн халдвартгүйтгэл

№	Өвчлөлийн хэлбэр	Халдвартгүйтгэх эд зүйлсийн нэр	Байнгын халдвартгүйтгэл	Эцсийн халдвартгүйтгэл
1.	Бүх төрлийн	Өвчтөнд үйлчлэхэд хэрэглэсэн хамгаалах өмсгөл, толгойн ба гарын алчуур, тахлын халад, хөвөн маарлин маск	<ul style="list-style-type: none"> 1.5 атм, 126 хэмд 120 минут автоклавдана. 0.5%-ийн идэвхжүүлэгч бүхий 3%-ийн устэрөгчийн хэт ислийн уусмалд живүүлж 24 цаг болгоно. 0.3%-ийн жавелионы уусмалд живүүлж 48 цаг болгоно. 	Байнгын халдвартгүйтгэлт эй адил
2.	Бүх төрлийн	Резинэн бээлий, боолтын материал хөвөн бөмбөлөг, сальфетик	<ul style="list-style-type: none"> Аюултай хог хаягдлын улаан уутанд хийж 2.0 атм, 132 хэмд 90 минут автоклавдаж халдвартгүй болгож шатаана. 	Хог хаягдал устгалын мэргэжлийн байгууллагаар устгуулах
3.	Бүх төрлийн	Гар биеийн бохирдсон хэсэг	<ul style="list-style-type: none"> 70°-ийн этилийн спирт 0.5%-ийн угаалгын бодистой 3%-ийн устэрөгчийн хэт ислийн уусмалын аль нэгээр 5-10 минут арчина. 	Байнгын халдвартгүйтгэлт эй адил
4.	Бүх төрлийн	Резин гутал шаахай	<ul style="list-style-type: none"> 0.5%-ийн угаагч нунтаг бүхий 6%-ийн устэрөгчийн хэт ислийн уусмал, 0.3%-ийн жавелионы уусмал 5%-ийн идэвхтэй гипохлорид кальцийн 20%-ийн сүүн ба тунгалагжуулсан уусмалын аль нэгээр 15 минутын зйтай 2 удаа арчина. 	Халдвартгүйтгэлийн уусмалыг сонгон дүрж тавин 120 минут байлгана.
5.	Уушги, үжил хэлбэрийн	Өвчтөн байгаа өрөө, тасалгааг	<ul style="list-style-type: none"> 0.5%-ийн угаалгын бодистой 6%-ийн устэрөгчийн хэт ислийн уусмал, 0.3%-ийн жавелионы уусмал 2%-ийн тунгалагжуулсан гипохлорит кальцийн уусмалуудыг сэвсгэр, нүхтэй гадаргад 900мл/м2, 	Байнгын халдвартгүйтгэлт эй адил

			гилгэр гадаргад 500мл/м ² орохоор тооцно. 2 дахь шүршилтээс хойш 90 минутын дараа саармагжуулалт хийн өрөөг савантай бүлээн усаар угааж цэвэрлэнэ.	
	Гэдэсний, арьсны хэлбэр	Өвчтөн байгаа өрөө, тасалгаа	<ul style="list-style-type: none"> ▪ 0.5%-ийн угаалгын бодистой 3%, 6%-ийн устэрөгчийн хэт ислийн уусмал, ▪ 1.5%-ийн идэвхтэй хлортой клорасептийн уусмал, ▪ 0.3%-ийн жавелионы уусмал ▪ 2%-ийн glutaraldehyde агуулсан уусмалаар арчих. ▪ Өрөөний халдвартгүйтгэлд нян устгах гэрлийг /15 минут/ хэрэглэж болно. 	Халдвартгүйтгэлийн бодисоос сонгож 30 минутын зайдай 2 удаа шүршиж халдвартгүйтгэнэ.
